**БҮТЭЭГДЭХҮҮН ХУВААХ ГЭРЭЭТ ОНГИ-V ТАЛБАЙ**

**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН БАРУУНБАЯН-УЛААН СУМЫН НУТАГТ ГАЗРЫН ТОСНЫ ХАЙГУУЛЫН ВЕЛОСИРАПТОР-1 ЦООНОГИЙН ӨРӨМДЛӨГ**

# 2023 ОНД ХЭРЭГЖҮҮЛСЭН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ

# БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

/ГАЗРЫН ТОСНЫ ХАЙГУУЛЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ДУГААР: 736/

/АЖ АХУЙН НЭГЖИЙН РЕГЕСТРИЙН ДУГААР: 5077982/

Хянасан:

Өвөрхангай аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын мэргэжилтэн:
.........................................................................................................Б.Болдбаатар

Биелэлтийг тайлагнасан:

Капкорп Монголиа ХХК-ийн ХАБЭАБО-ны хэлтсийн дарга:
.........................................................................................................Гэйри Нийл

Капкорп Монголиа ХХК-ийн ХАБЭАБО-ны хэлтсийн байгаль орчны мэргэжилтэн:......................................................................................... Д.Буянзул

**БҮТЭЭГДЭХҮҮН ХУВААХ ГЭРЭЭТ ОНГИ-V ТАЛБАЙ**

# ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН БАРУУНБАЯН-УЛААН СУМЫН НУТАГТ ГАЗРЫН ТОСНЫ ХАЙГУУЛЫН ВЕЛОСИРАПТОР-1 ЦООНОГИЙН ӨРӨМДЛӨГ

2023 ОНД ХЭРЭГЖҮҮЛСЭН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ

БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

/ГАЗРЫН ТОСНЫ ХАЙГУУЛЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ДУГААР: 736/

/АЖ АХУЙН НЭГЖИЙН РЕГЕСТРИЙН ДУГААР: 5077982/

Хянасан:

Өвөрхангай аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын мэргэжилтэн:
..........................................................................................................................Б.Болдбаатар

Биелэлтийг тайлагнасан:

Капкорп Монголиа ХХК-ийн ХАБЭАБО-ны хэлтсийн дарга:
..........................................................................................................................Гэйри Нийл

Капкорп Монголиа ХХК-ийн ХАБЭАБО-ны хэлтсийн байгаль орчны мэргэжилтэн:...................................................................................................... Д.Буянзул

# Агуулга

1. 2023 ОНЫ ХАЙГУУЛЫН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА .......................... 3
1.1. Төслийн товч танилцуулга .......................... 4
1.2. Гүйцэтгэсэн хайгуулын ажлын товч танилцуулга .......................... 5
1.3. Өрөмдлөгийн талбайн бэлтгэл ажил .......................... 9
2. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ 16
3. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ .......................... 24
4. ТҮҮХ СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ .......................... 30
5. ОСОЛ ЭРСДЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ .......................... 32
6. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ .......................... 40
7. ХИМИЙН БОДИСЫН ЭРСДЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ .. 47
8. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР .......................... 52
9. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ .......................... 53
10. БОМТ -НИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛӨЛД ӨРТӨХ ОРШИН СУУГЧИД, ОРОЛЦОГЧ ТАЛУУДАД ТАЙЛАГНАХ АЖЛЫН ХЭРЭГЖИЛТ .......................... 55
11. 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зардлын хураангуй .......................... 61
Дүгнэлт .......................... 62

**Тайлангийн зургийн жагсаалт**

Зураг 1. Бүтээгдэхүүн хуваах гэрээт Онги-V талбайн байршлын зураг .......................... 4
Зураг 2. Онги-V талбайн засаг захиргааны зураг .......................... 5
Зураг 3. Тээврийн хэрэгслийн нүүдлийн үед хатуу хучилттай замаас шороон зам руу салах хэсгээс машин тус бүрийг тосч талбай хүртэл дагуулан явсан .......................... 7
Зураг 4. Нүүдлийн үед тээврийн хэрэгслүүдийг дагуулан явсан байдал .......................... 8
Зураг 5. Өрөмдлөгийн талбайн ерөнхий төлөвлөлт .......................... 9
Зураг 6. Өрөмдлөгийн талбайн бэлтгэл ажил эхлэхээс өмнөх өрөмдлөгийн талбайн ерөнхий харагдах байдал .......................... 10
Зураг 7. Өрөмдлөгийн талбайгаас 44 загийг нүүлгэн шилжүүлсэн .......................... 10
Зураг 8. Өрөмдлөгийн талбай дээр шингэн хаягдлын сан байгуулахаар хэмжилт хийж буй байдал .......................... 11
Зураг 9. Өрөмдлөгийн талбай болон кемпийн харагдах байдал (2023.7 сар) .......................... 11
Зураг 10. Өрөмдлөгийн талбайн харагдах байдал (2023.7 сар) .......................... 12
Зураг 11. Кемпийн төлөвлөлт .......................... 13
Зураг 12. Кемпийн талбай дээрх зураг .......................... 13
Зураг 13. Талбай дээрх кемпийн харагдах байдал .......................... 14
Зураг 14. Техникийн усан хангамжийн худгийн тоолууржуулалт ба баталгаажуулалт .......................... 15

Зураг 15. Усны тоолуурын баталгаажуулалтын гэрчилгээ .................................................. 15

**Тайлангийн хавсралтын жагсаалт**

Хавсралт 1. Улсын бүртгэлийн гэрчилгээ .................................................. 68
Хавсралт 2. Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл .................................................. 69
Хавсралт 3. Газар ашиглах зөвшөөрөл .................................................. 70
Хавсралт 4. Гол мөрний урсац бүрэлдэх эх, ойн сан бүхий газрын хилийн заагтай давхцалгүй болох тухай лавлагаа .................................................. 71
Хавсралт 5. Байгаль орчны барьцаа хөрөнгө байршуулсан тооцооны үлдэгдлийн баталгаа .................................................. 73
Хавсралт 6. Ус ашиглах боломжит нөөцийн дүгнэлт .................................................. 74
Хавсралт 7. Ус ашиглуулах дүгнэлт .................................................. 77
Хавсралт 8. Ус ашиглах зөвшөөрөл, гэрээ .................................................. 80
Хавсралт 9. Гучин-Ус сумын засаг даргын худаг ашиглах зөвшөөрөл .................................................. 85
Хавсралт 10. Худгийн пасспорт .................................................. 86
Хавсралт 11. Өрөмдлөг, ахуйн хэрэглээнд худгаас авч ашигласан усны бүртгэл .................................................. 88
Хавсралт 12. Ус ашигласны төлбөрийн баримт .................................................. 89
Хавсралт 13. Кемпийн ахуйн хог хаягдлыг зохицуулах гэрээ .................................................. 90
Хавсралт 14. Ахуйн хог хаягдлын зөөвөрлөсөн бүртгэл .................................................. 92
Хавсралт 15. Ахуйн хог хаягдлын төлбөр төлсөн баримт .................................................. 93
Хавсралт 16. Ахуйн бохир ус нийлүүлэх гэрээ (кемпийн үйлчилгээний гэрээт Геомин ХХК) .................................................. 94
Хавсралт 17. Ахуйн бохир ус зөөвөрлөж нийлүүлсэн бүртгэл (кемпийн үйлчилгээний гэрээт Геомин ХХК) .................................................. 97
Хавсралт 18. Велосираптор -1 цооногийн өрөмдлөгийн ажлын үед дагаж мөрдсөн “Нэг замын бодлого” .................................................. 98
Хавсралт 19. Галын аюулгүй байдлын дүгнэлт .................................................. 101
Хавсралт 20. Өрөмдлөгийн гэрээт гүйцэтгэгч Мэжор Дриллинг ХХК-ний ВР-1 цооногийн үед хэрэгжүүлж ажиллах БОМТ .................................................. 102
Хавсралт 21. Өрөмдлөгийн гэрээт гүйцэтгэгч Мэжор Дриллинг ХХК-ний Химийн бодисын ашиглах тусгай зөвшөөрөл .................................................. 103
Хавсралт 22. Өрөмдлөгийн гэрээт гүйцэтгэгч Мэжор Дриллинг ХХК-ний Аюултай хог хаягдал шилжүүлэх гэрээ .................................................. 106
Хавсралт 23. Өрөмдлөгийн гэрээт гүйцэтгэгч Мэжор Дриллинг ХХК-ний Аюултай хог хаягдлыг шилжүүлсэн дагалдах бичиг .................................................. 109
Хавсралт 24. Өрөмдлөгийн гэрээт компаний ажилчдын химийн бодистой харьцаж ажиллах үеийн аюулгүй ажиллагааны сургалтын сертификат .................................................. 110
Хавсралт 25. Агаарын түр зурвас тогтоосон акт .................................................. 112
Хавсралт 26. Баруунбаян-Улаан сумын засаг даргын тодорхойлолт .................................................. 114
Хавсралт 27. Гучин-Ус сумын засаг даргын тодорхойлолт .................................................. 115
Хавсралт 28. Яаралтай үед авах хариу арга хэмжээний төлөвлөгөө .................................................. 116
Хавсралт 29. Эрүүл мэндийн яаралтай нүүлгэн шилжүүлэлтийн төлөвлөгөө .................................................. 116
Хавсралт 30. Үйл ажиллагааны өмнөх орчны хяналт шинжилгээний ажлын тайлан .................................................. 116
Хавсралт 31. Үйл ажиллагааны үеийн орчны хяналт шинжилгээний ажлын тайлан .................................................. 116
Хавсралт 32. Үйл ажиллагааны дараах үеийн орчны хяналт шинжилгээний ажлын тайлан .................................................. 116
Хавсралт 33. Техникийн болон биологийн нөхөн сэргээлтийн ажлын тайлан .................................................. 116
Хавсралт 34. Цацраг үүсгүүр ашиглалтын талаарх тайлан .................................................. 116

# 1. 2023 ОНЫ ХАЙГУУЛЫН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

## 1.1. Төслийн товч танилцуулга

“Сентрал Азиан Петролеум Корпорэйшн Лимитед” компани нь 2009 оны 7 дугаар сард Монгол Улсын Засгийн газартай газрын тосны хайгуулын Онги V талбайд “Бүтээгдэхүүн хуваах гэрээ” /БХГ/ байгуулан газрын тосны хайгуул, судалгааны ажлыг 14 дэх жилдээ явуулж байна.

“Капкорп Монголиа” ХХК нь “Сентрал Азиан Петролеум Корпорэйшн Лимитед” компанийн охин компани бөгөөд эх компанийн өмнөөс Монгол дахь үйл ажиллагааг хариуцан ажилладаг. Газрын тосны хайгуулын БХГ-т Онги-V талбай нь Монгол орны баруун урд хэсэгт, Улаанбаатар хотоос баруун урагш 450 орчим километрт орших бөгөөд нийт талбайн хэмжээ 32, 030 $км^2$ байснаас БХГ-ний 7.1 –ийн а/ заалт болон “Газрын тосны тухай хууль”-ийг хэрэгжүүлэх журмын 14.1 заалтуудыг үндэслэн 2011 оны 10 дугаар сарын 31-ны өдөр хайгуулын үйл ажиллагаа явуулахгүй талбайн хэсгийг буцааж өгснөөр нийт хайгуулын талбай 21, 100 $км^2$ болсон ба хамгийн сүүлд 2020 онд хайгуулын талбайг хэсэгчлэн буцааснаар шинэчлэгдсэн талбайн хэмжээ нийт 7936,9 $км^2$ болсон байна. Хайгуулын талбайн байршлыг Зураг 1-д харуулав.




| Цэгийн дугаар | Солбицол, WGS 84 | |
|---|---|---|
| | Уртраг | Өргөрөг |
| 1 | 101° 30' 1.775" E | 45° 24' 28.800" N |
| 2 | 102° 27' 8.197" E | 45° 24' 28.800" N |
| 3 | 102° 27' 8.197" E | 44° 52' 12.000" N |
| 4 | 101° 30' 1.775" E | 44° 52' 12.000" N |

| Цэгийн дугаар | Солбицол, WGS 84 | |
|---|---|---|
| | Уртраг | Өргөрөг |
| 5 | 102° 57' 48.190" E | 45° 43' 35.717" N |
| 6 | 102° 57' 48.190" E | 45° 9' 43.200" N |
| 7 | 102° 39' 59.000" E | 44° 40' 0.000" N |
| 8 | 102° 39' 59.000" E | 45° 0' 0.000" N |

Зураг 1. Бүтээгдэхүүн хуваах гэрээт Онги-V талбайн байршлын зураг

Онги-V талбай нь засаг захиргааны нэгжийн хувьд Өвөрхангай аймгийн Баруунбаян-Улаан, Гучин-ус, Богд, Баянгол, Төгрөг, Нарийнтээл, Хайрхандулаан сумдын нутаг дэвсгэр хамрагддаг. Онги-V талбай орших нутаг дэвсгэрийн засаг захиргааны нэгжийг Зураг 1.2-т үзүүлэв.




Зураг 2. Онги-V талбайн засаг захиргааны зураг

## 1.2. Гүйцэтгэсэн хайгуулын ажлын товч танилцуулга

Бүтээгдэхүүн хуваах гэрээ /БХГ/ -т газрын тосны хайгуулын Онги-V талбайд 2023 онд /гэрээт 14 дэх жил/ газрын тосны хайгуулын ажлын хүрээнд Өвөрхангай аймгийн Баруунбаян-Улаан, Гучин-Ус сумдын нутагт 150 $км^2$ талбайг хамарсан 3 хэмжээст чичирхийллийн хайгуул судалгааны ажил, болон Баруунбаян-Улаан сумын нутагт хайгуулын тулгуур 2 цооногийг өрөмдөнө. Өрөмдлөгийн үр дүнгээс хамаарч, өөрөөр хэлбэл газрын тостой эсвэл газрын тостой байх шинж тэмдэг илэрвэл тус цооногуудад цооногийн туршилт, шингэн хагалбар зэрэг өрөмдлөгийн дараах ажлуудыг хийхээр төлөвлөсөн байсан.

2023 онд төлөвлөсөн хайгуулын ажлын хүрээнд Баруунбаян-Улаан сумын нутагт Велосираптор-1 газрын тосны хайгуулын цооногийн өрөмдлөгийн ажлыг өрөмдлөгийн гэрээт гүйцэтгэгч “Мэжор Дриллинг ХХК” нь 2 ээлж, 24 цагаар ажиллаж 2023 оны 6-р сарын 13-аас 7-р сарын 20 хүртэл нийт 37 хоногийн хугацаанд хийж гүйцэтгэлээ.

Газар ашиглалтыг зохион байгуулахдаа аль болох бага зай, талбай эзлүүлэн зохистой байршуулах, нөгөө талаар байгаль орчинд учрах сөрөг нөлөөллийг хамгийн бага байлгах, өрөмдлөгийн талбайн хашаанаас гадагш ямарваа нэг үйл ажиллагаа явуулахгүй байх зэрэг нөхцлийг хангаж ажиллахыг зорьсон. Төслийн бүх үйл ажиллагааг 0.8 га талбайд багтаан явуулсан. Үүнээс өрөмдлөгийн талбай 0,42 га талбайд (70м x 60м хэмжээтэй торон хашаа бүхий) өрөмдлөгийн тоног төхөөрөмж, өрмийн шингэн хаягдлын сан, химийн бодисын агуулах зэрэг бүрэн багтсан. Хээрийн ангийн кемпийг 0,385 га талбайд байгуулсан ба үүнд ахуйн хог хаягдал цуглуулах цэг, бохирын септик байрлуулсан

талбайнууд багтсан. Орон нутгийн төв замаас салаалан өрмийн талбайд хүрэх 370 метр шинэ зам гаргасан.

Нэг замын зааварчилгааг зураглан боловсруулж Гучин-Ус сум, Баруунбаян-Улаан сумын засаг дарга нарт танилцуулан төсөл хэрэгжих хугацаанд энэхүү замаар тээвэр, ложистикыг зохицуулах талаар харилцан зөвшилцөж, нэг замын маршрутыг дагаж мөрдөж байгаад хяналт тавьсан. Үүнд: өрөмдлөгийн ажлын гэрээт гүйцэтгэгч болох Мэжор Дриллинг ХХК-наас тухай бүр тээвэр хийгдэх төлөвлөгөөг гаргуулан авч манай компаний харилцааны хэлтсийн ажилтан, жолооч нар Арвайхээр хотоос 95 км-т хатуу хучилт бүхий замаас шороон зам руу салах хэсгээс том оврын тээврийн хэрэгслийн ачилт хийсэн тээврийн хэрэгсэл бүрийг тосож аван төслийн талбай хүртэл тогтоосон маршрутын дагуу дагуулан явж байсан.





Зураг 3. Тээврийн хэрэгслийн нүүдлийн үед хатуу хучилттай замаас шороон зам руу салах хэсгээс машин тус бүрийг тосч талбай хүртэл дагуулан явсан





Зураг 4. Нүүдлийн үед тээврийн хэрэгслүүдийг дагуулан явсан байдал

## 1.3. Өрөмдлөгийн талбайн бэлтгэл ажил

Өрөмдлөгийн талбайн бэлтгэл ажлыг ажил эхлэхээс өмнө өрөмдлөгийн гэрээт, өрмийн талбайн бэлтгэл ажил гүйцэтгэх гэрээт, кемпийн үйлчилгээний гэрээт компаниудтай мөн Баруунбаян-Улаан сумын байгаль орчны улсын байцаагчийн хамт өрөмдлөгийн тогтоосон цэгт урьдчилан ирж танилцан кемп байгуулах газрыг тухайн газрын газарзүйн байрлал, байгалийн нөхцөл байдалтай уялдуулан сонгож, мөн өрмийн талбайг аль болох газрын гадаргын эвдрэл бага байлгахад анхааран зохион байгуулалтыг хийж харилцан ярилцаж тохиролцсон (Зураг 5).

Өрөмдлөгийн талбайн хувьд зулзаган заг (*Haloxylon ammodendron*) зонхилон ургасан 1м$^2$ дахь тусгаг бүрхэцэд 1-2 загийн зүйл тохиолдож байсан. Тиймээс өрөмдлөгийн талбайг 60м х 70м хэмжээтэйгээр хамгийн бага хэмжээнд өрөмдлөгийн талбайг бэлтгэж харин кемпийн талбайг заг бүхий байгалийн тогтоц хэсгээс зайдуу өрөмдлөгийн талбайн баруун урд зүгт ойролцоогоор 300м зайд байгуулсан (Зураг 7 ).




Зураг 5. Өрөмдлөгийн талбайн ерөнхий төлөвлөлт



Зураг 6. Өрөмдлөгийн талбайн бэлтгэл ажил эхлэхээс өмнөх өрөмдлөгийн талбайн ерөнхий харагдах байдал





Зураг 7. Өрөмдлөгийн талбайгаас 44 загийг нүүлгэн шилжүүлсэн



Зураг 8. Өрөмдлөгийн талбай дээр шингэн хаягдлын сан байгуулахаар хэмжилт хийж буй байдал



Зураг 9. Өрөмдлөгийн талбай болон кемпийн харагдах байдал (2023.7 сар)



Зураг 10. Өрөмдлөгийн талбайн харагдах байдал (2023.7 сар)




Зураг 11. Кемпийн төлөвлөлт



Зураг 12. Кемпийн талбай дээрх зураг



Зураг 13. Талбай дээрх кемпийн харагдах байдал

**Ус ашиглалт:** Технологийн усны хангамжийг Гучин-Ус сумын нутагт 2018 онд манай компани Эрдэнэдриллинг ХХК-аар гаргуулан орон нутагт гаргаж хүлээлгэн өгсөн худгийг Гучин-Ус сумын Засаг даргаас ашиглах зөвшөөрөл аван ашигласан. Ундны усанд савласан ус зөөврөөр ашигласан.

Гучин-Ус сумын байгаль орчны байцаагчийг байлцуулан гүний худагт усны тоолуур суурилуулж (Зураг 14) ашигласан. Өрөмдлөг, ахуйн хэрэгцээнд ашигласан усны хэмжээг өдөр бүр бүртгэж (“Капорп Монголиа” ХХК)-д илгээж байв /Хавсралт 11/. Нийт 786м3 ус ашигласан ба үүнээс 492 тн ус өрөмдлөгт, 294 тн усыг ахуйн хэрэглээнд ашиглаж усны төлбөрт 2,171,673 төгрөг төлсөн (Хавсралт 12).




Зураг 14. Техникийн усан хангамжийн худгийн тоолууржуулалт ба баталгаажуулалт



MASM СТАНДАРТ, ХЭМЖИЛ ЗҮЙН ГАЗАР

**УСНЫ ТООЛУУРЫН БАТАЛГААЖУУЛАЛТЫН ГЭРЧИЛГЭЭ**

**№ ЭУ ...081266...**

Кафорт монгол -д
(хэрэглэгчийн нэр)
ашиглаж байгаа Zenner - 40 загварын 10 м³/ц
хэмжих хязгаартай, 40 мм-ийн голчтой № 101000135 -ын
халуун, хүйтэн усны тоолуурыг № 015 лацаар битүүмжилж
(доогуур зурах)
2025 оны 05 -р сарын 18 -ны өдөр хүртэл улсын баталгаажуулалтын гэрчилгээ олгов.

Шалгалтын дараах заалт: 02811 м³

Лабораторийн тэмдэг

Улсын шалгагчийн гарын үсэг, тэмдэг

2023 оны 05 -р сарын 18 -ны өдөр

Зураг 15. Усны тоолуурын баталгаажуулалтын гэрчилгээ

## 2. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

**Агаарын чанарт нөлөөлөх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт**

| Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулахаар төлөвлөсөн арга хэмжээ | Хариуцах эзэн | Хэрэгжүүлсэн байдал |
|---|---|---|
| **Агаар орчин** | | |
| Тээврийн хэрэгсэл зорчих нэгдсэн маршрут буюу НЭГ ЗАМЫН БОДЛОГО баримтлах, чанд мөрдүүлэх, тэмдэглэгээ байршуулах | Гэрээт гүйцэтгэгч: “Мон баг” ХХК<br><br>Хяналт тавин хамтран ажиллагч: “Капкорп Монголиа” ХХК | Нэг замын маршрутыг гаргаж Гучин-Ус, Баруунбаян-Улаан сумын засаг дарга нарт танилцуулсан. “Нэг замын бодлого маршрут /Хавсралт 18/. Өрөмдлөгийн тоног төхөөрөмжийг УБ хотоос өрөмдлөгийн талбай руу тээвэрлэх үед тээврийн хэрэгсэлүүдийг Арвайхээр хотоос хатуу хучилттай замаар яван шороон зам руу салах 92 км-тэмдэглэгээнээс манай компаний харилцааны ажилтан, жолооч нар нэг бүрчлэн нэг замын маршрутын дагуу хурдны хязгаартайгаар дагуулан явж өрөмдлөгийн талбайд хүргэж байсан.<br>   |
| Хурдны хязгаарлалтын тэмдэглэгээ | | Өрөмдлөгийн талбай кемп хоорондох зам дагуу хурдны хязгаарлалтын тэмдэг байрлуулан техникийн хөдөлгөөний улмаас агаар орчинд тоосжилт үүсэх нөхцлийг бууруулах арга хэмжээ авсан. |

| | | |
|---|---|---|
| | |   |
| Цаг агаар, уур амьсгал, хуурайшилтын нөхцөл байдалтай уялдуулж зам талбайн усалгааг хийж тоосжилт үүсэхийг хязгаарлах | Гэрээт гүйцэтгэгч:<br>“Мэжор дриллинг” ХХК<br><br>Хяналт тавин хамтран ажиллагч:<br>“Капкорп Монголиа” ХХК | Велосираптор-1 цооногийн өрөмдлөгийн ажил явагдсан 6-р сарын 10-аас 7-р сарын 20 хүртэлх хугацаанд хур тунадас элбэг үер ус ихтэй байсан тул зам талбайн усалгаа хийх нөхцөл ихээр үүсээгүй. Хэдий тийм ч замын усалгааг шаардлагатай тохиолдолуудад хийж байсан.<br>   |

| | | |
|---|---|---|
| Агаарын чанарын хяналт шинжилгээ хийж, үр дүнг нэгтгэн тайлагнах | | Агаар орчны хяналт шинжилгээний ажлыг өрөмдлөгийн талбайд ажил эхлэхээс өмнө 2022 оны 9-р сард болон өрөмдлөгийн ажил явагдаж 2023 оны 7-р сарын 5-нд тус тус мэргэжлийн байгууллагаар хийж гүйцэтгүүлсэн (Орчны хяналт шинжилгээний ажлын тайланг энэхүү тайланд хавсаргасан). |

**Гадаргын ба газрын доорх усны нөөцөд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт**

| Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулахаар төлөвлөсөн арга хэмжээ | Хариуцах эзэн | Хэрэгжүүлсэн байдал |
|---|---|---|
| **Гадаргын болон газрын доорх усан орчин** | | |
| Ус ашиглуулах дүгнэлт гаргуулан, сумын засаг даргатай ус ашиглах гэрээ байгуулан ажиллах. | “Капкорп Монголиа” ХХК | Өвөрхангай аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газраас ус ашиглах дүгнэлт гаргуулан уг дүгнэлтэд үндэслэн Гучин-Ус сумын засаг даргатай ус ашиглах гэрээ байгуулан ажилласан, ус ашиглах дүгнэлт гэрээг Хавсралт 7, 8. |
| Хөрсөнд ямар нэгэн хаягдал бохир шингэн зүйлс /угаадас, шатах тослох материал, түлш г.м/ ил задгай хаяхгүй байх тал дээр хяналт тавьж ажиллах | Гэрээт гүйцэтгэгч: “Мэжор дриллинг” ХХК<br><br>Кемпийн гэрээт гүйцэтгэгч Геомин ХХК<br><br>Хяналт тавин хамтран ажиллагч: “Капкорп Монголиа” ХХК |   <br>Ахуйн шингэн хаягдал, хар саарал усыг бохирын септик танк байрлуулан тогтмол Хайрхандулаан сумын цэвэрлэх байгууламж руу зөөж байсан. Тиймээс хөрсөнд ахуйн бохироос ямар нэгэн бохирдол төсөл хэрэгжих хугацаанд үүсээгүй. Бохир ус зөөвөрлөлтийн бүртгэлийг Хавсралт 17. |

| | | |
|---|---|---|
| Усан орчны чанарын хяналт шинжилгээ хийж, үр дүнг нэгтгэн тайлагнах | Гэрээт гүйцэтгэгч: “Мэжор дриллинг” ХХК | Өрөмдлөгийн үйл ажиллагаа явагдаж байх Орчны хяналт шинжилгээний ажлыг мэргэжлийн байгууллагаар хийж гүйцэтгүүлсэн. Орчны хяналт шинжилгээний ажлын тайланг энэхүү тайланд хавсаргасан. |

**Хөрсөн орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт**

| Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулахаар төлөвлөсөн арга хэмжээ | Хариуцах эзэн | Хэрэгжүүлсэн байдал |
|---|---|---|
| **Хөрс** | | |
| Ил задгай ахуйн хог хаягдал хаяхаас сэргийлэн кемпэд хогийн сав байршуулах | Гэрээт гүйцэтгэгч: “Мэжор дриллинг” ХХК<br><br>Кемпийн үйлчилгээний гэрээт гүйцэтгэгч: Геомин ХХК<br><br>Хяналт тавин хамтран ажиллагч: “Капкорп Монголиа” ХХК | Кемпийн талбайд, гал тогоо, шаардлагатай цэгүүдэд хогийн сав байршуулан ил задгай хог хаягдахаас урьдчилан сэргийлсэн.<br> |

| | | |
|---|---|---|
| Өрөмдлөг, хаягдлын сан байгуулах талбайн шимт хөрсийг тусад нь авч хадгалан цооног хаах битүүмжлэх, хаягдлын сангийн нөхөн сэргээлтэд дахин ашиглах зориулалтаар шимт хөрсний овоолго хийнэ | Өрмийн талбайн бэлтгэл ажлын гүйцэтгэгч Монбаг ХХК,<br><br>Хяналт тавьж ажилласан: Мэжор Дриллинг, Капкорп Монголиа | Өрмийн талбайн бэлтгэл ажлын хүрээнд 60х70 харьцаатай талбайд 20 см зузаантай хөрс хуулалтын ажил хийгдсэн. энэхүү шимт хөрсийг өрөмдлөгийн талбайн зүүн урд талд овоолго хийж, стандартын дагуу самбар байршуулан хадгалсан.<br> |
| | | Өрөмдлөгийн талбайд шатахуун түгээх зориулалтын тээврийн хэрэгслийг зогсоож байрлуулах талбайд хөрсөнд шатах тослох материал асгарахаас урьдчилан сэргийлж геомембран дэвсэж бэлтгэсэн талбайд байрлуулж байсан.<br> |

| | | |
|---|---|---|
| | | Кемпийн дизель генераторыг мөн доор нь хөрсөнд бохирдол үүсэхээс сэргийлэн төмөр хаалт хамгаалалт бүхий газар байрлуулсан.  |

**Ургамлан нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт**

| Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулахаар төлөвлөсөн арга хэмжээ | Хариуцах эзэн | Хэрэгжүүлсэн байдал |
|---|---|---|
| **Ургамлан нөмрөг** | | |
| Эвдэгдсэн талбайд нөхөн сэргээлтийн ажлыг өрөмдлөгийн ажил дууссаны дараа хугацаа алдалгүй хийж гүйцэтгэх | Гэрээт гүйцэтгэгч: “Мэйжор дриллинг” ХХК<br><br>Кемпийн гэрээт гүйцэтгэгч Геомин ХХК<br><br>Хяналт тавьж ажилласан: “Капкорп Монголиа” ХХК | Нөхөн сэргээлтийн ажлыг өрөмдлөгийн ажил дууссанаас хойш 1 сарын дараа өрмийн шингэн хаягдлын сан дахь шингэн тодорхой хэмжээгээр ууршиж нөхцлийг бүрдүүлсний дараа 2023 оны 9-р сард эхлүүлэн хийж гүйцэтгэсэн. Нөхөн сэргээлтийн ажлын тайланг Хавсралт 33-аас үзнэ үү. |
| | | Өрөмдлөгийн талбайд заг ихээр ургасан байсан бөгөөд өрөмдлөгийн талбайд өртөж байсан загнуудыг өөр талбайд шилжүүлэн суулгасан. Нийт 44 загийг өөр талбайд шилжүүлэн суулгаж усалгаа хийсэн. Өрөмдлөгийн ажил явагдаж байх 1 сарын хугацаанд өдөр бүр оройн цагаар усалгаа хийж шилжүүлэн суулгасан загийн ургалтыг дэмжсэн.<br>   |
| Ургамлан бүрхэвчийн мониторингийн судалгаа хийх | Мэргэжлийн байгууллага | Талбайд орчны хяналт шинжилгээний мониторингийн ажлыг 2022 оны 9-р сард, 2023 оны 7-сарын 5-6-нд, 2023 оны 10-р сарын 1-2 нд мэргэжлийн байгууллагаар тус тус хийж гүйцэтгүүлсэн. |

| | | |
|---|---|---|
| | |    |
| | | |

**Амьтны аймагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт**

| Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулахаар төлөвлөсөн арга хэмжээ | Хариуцах эзэн | Хэрэгжүүлсэн байдал |
|---|---|---|
| **Амьтны аймаг** | | |
| Төсөл хэрэгжих талбайн ан амьтдын талаар мэдээлэл судалгааг орчны хяналт шинжилгээний ажлын хүрээнд хийх | Орчны хяналт шинжилгээний ажил мэргэжлийн байгууллага, Капкорп Монголиа ХХК | Төсөл хэрэгжих талбайн орчмын амьтны ажиглалт судалгааны ажлыг өрөмдлөгийн талбайн орчимд ажил эхлэхээс өмнө 2022 оны 9-р сард орчны хяналт шинжилгээний ажлын хүрээнд мэргэжлийн байгууллагаар хийж гүйцэтгүүлсэн. Орчны хяналт шинжилгээний ажил нь ВР-1 өрөмдлөгийн ажлын хүрээнд 3 удаагийн давтамжтай хийгдсэн. ОХШ-ний тайланг Хавсралт 30, 31, 32 үзнэ үү.<br>Мөн Капкорп Монголиа ХХК нь 2016 онд газрын тосны хайгуулын Онги-V талбай хэмжээнд байгаль орчны хээрийн суурь, сэрэмжлэх байдлын судалгаар мэргэжлийн байгууллагаар хийж гүйцэтгүүлсэн. Энэхүү суурь судалгааны ажлын үр дүн маш сайн байсан тухайн судалгааны ажлын хүрээнд Баруунбаян-Улаан, Гучин-Ус сумын нутаг дахь амьтны аймгийн талаарх судалгаар хийсэн. |

## 3. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ

| Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулахаар төлөвлөсөн арга хэмжээ | Хариуцах эзэн | Хэрэгжүүлсэн байдал |
|---|---|---|
| **Нөхөн сэргээлтийн ажил** | | |
| Өрөмдлөгийн талбайн техникийн болон биологийн нөхөн сэргээлт:<br>Үүнд: өрөмдлөгийн шингэн хаягдлын сан, ахуйн шингэн хаягдлын нүх, тоног төхөөрөмж байрласан талбай, үйл ажиллагааны улмаас талхлагдсан талбай г.м<br>**Жич:** өрөмдлөгийн талбайн техникийн нөхөн сэргээлтийн ажлыг тухайн цооногт хийгдэх бүх туршилт, судалгаа, шингэн хагалбарын ажлууд хийгдэж дууссаны дараа гүйцэтгэнэ. | Нөхөн сэргээлтийн ажлын гэрээт компани, Капкорп Монголиа ХХК | 7-р сарын 20-ны өдөр өрөмдлөгийн ажил дуусаж өрөмдлөгийн талбай дахь тоног төхөөрөмжийг нүүлгэн шилжүүлж, шаардлагатай хэсгүүдэд хөрсний хэлбэржүүлэлт тэгшилгээг хийн өрмийн талбайг хашаатай хэвээр орон нутгаас манаач айл буулган үлдээсэн.<br>Кемпийн талбайг нүүлгэн ойр орчмын хог хаягдлыг түүж цэвэрлэн, бохирын септик танк, шугам хоолойн хэсгүүдийн талбайг тэгшлэх нөхөн дүүргэх ажлуудыг хийж нөхөн сэргээлт хийхэд бэлэн болгож үлдээсэн.<br>Өрөмдлөг, кемпийн талбай дахь нүүдэл хийгдэж дууссаны дараа Баруунбаян-Улаан сумын байгаль орчны улсын байцаагч, сум дундын цагдаагийн хэсгийн төлөөлөгч нар талбай дээр ирж танилцсан. Энэ үед нөхөн сэргээлтийн ажлын талаар харилцан санал солилцож өрөмдлөгийн талбайд биологийн нөхөн сэргээлтийн ажлын хүрээнд сумын төвийн мод үржүүлгийн газраас загийн суулгацын тариалалтыг намар хийхээр төлөвлөсөн. Үүнээс хойш нөхөн сэргээлтийн ажлыг гүйцэтгэх гэрээт байгууллагын сонгон шалгаруулалтыг хийж талбай дээр ажил 9-р сарын 15-ны өдрөөс эхлэн 10-р сарын 5-нд хооронд хийж дуусгасан.<br>Талбайн нүүлгэн шилжүүлэлтийн дараах зургийг харна уу. Нөхөн сэргээлтийн ажлын дэлгэрэнгүй тайланг Хавсралт 33.<br>  |

Газрын тосны хайгуул, олборлолт, ашиглалтын үйл ажиллагаанаас эвдэрсэн газрын нөхөн сэргээлт MNS6200:2010 стандартад цооног хаах битүүмжлэхэд тавигдах шаардлагыг тодорхойлсон байдаг.

Энэ шаардлагын дагуу газрын тосны хайгуул ашиглалтын цооногийг цаашид өөр зориулалтаар ашиглахгүй нөхцөлд цооногийг төмөр бетон хийц ашиглан битүүмжилж, амсрын бэхэлгээний янданг газрын гадаргуутай тэгш түвшинд тайрч, төмрөөр таглаж гагнах ба таган дээр цооногийн нэр, дугаар, хаасан огноог бичиж тэмдэглэх шаардлагатай байдаг. Үүний дагуу Велосираптор-1 цооногийг хааж битүүмжлэсэн. Доорх зураг харна уу.





Нөхөн сэргээлтийн ажлын явцад манай компаниас Өвөрхангай аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газарт хаягдлын сангийн саармагжуулалтын явцтай танилцах хүсэлтийг хүргүүлснээр тус газрын дарга Г.Баясгалан, Капкорп Монголиа ХХК-ний байгаль орчны мэргэжилтэн Д.Буянзул нар талбай дээр 2023 оны 9-р сарын 28-ны өдөр нөхөн сэргээлтийн ажлын явцтай танилцаж хаягдлын санг өлгийдөх ажлыг үргэжлүүлэн хийхээр тохиролцсон.

| | | |
|---|---|---|
| | |   Хаягдлын сангийн саармагжуулалт, техникийн нөхөн сэргээлтийн явтай танилцаж буй байдал (нөхөн сэргээлтийн гэрээт гүйцэтгэгч байгууллага, аймгийн Байгаль орчин аялал жуулчалын газар, Капкорп Монголиа ХХК-ний төлөөлөл нар) |

| | | |
|---|---|---|
| | | Үүний дараа Баруунбаян-Улаан сумын мод үржүүлгийн газраас загийн суулгац худалдан авахаар төлөвлөсний дагуу тус мод үржүүлгийн газарт нөхөн сэргээлтийн компани хамт очиж танилцан худалдан авалт хийх загийг сонгон харилцан тохиролцсон.<br> <br>Баруунбаян-Улаан сум дахь мод үржүүлгийн газар |

| | | |
|---|---|---|
| | | 9-р сарын 29, 30-ны өдрүүдэд биологийн нөхөн сэргээлтийн ажил буюу загийн суулгацын тариалалтын ажлыг хийж эхлэсэн. Ингэхдээ загийн суулгац бүрийн нүхийг гараар бэлтгэн тогоо үүсгэж нийт 672 загийг өрөмдлөгийн талбайн хэмжээнд тариалалт, усалгааны ажлыг хийсэн. Баруунбаян-Улаан сумын байгаль орчны улсын хяналтын байцаагч Д.Даваадагва зөвлөн тусалж, Капкорп Монголиа ХХК-аас хяналт тавьж нөхөн сэргээлтийн гэрээт байгууллагатай талбай дээр хамтран ажиллаа.<br><br><br><br> |

| | | |
|---|---|---|
| | | |

**Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт**

| Дүйцүүлэн хамгааллын ажлын хүрээнд төлөвлөсөн ажил | Хариуцах | Хэрэгжүүлсэн байдал |
|---|---|---|
| **Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт** | | |
| Газрын тосны хайгуулын ажлын үед хайгуул явагдсан талбайд тухай бүрт нь нөхөн сэргээлт хийж байх ба хайгуулын ажил дуусч олборлолтын шатанд шилжих үед дүйцүүлэн хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлнэ. | Капкорп Монголиа ХХК | БОННҮ-д газрын тосны хайгуулын үйл ажиллагаа явагдаж байгаа тул дүйцүүлэн хамгаалах ажил төлөвлөгдөөгүй ба хийгдэх шаардлагагүй гэж үзсэн.<br><br>Төслийн өмнөх үе шатанд, байгаль орчны төлөв байдлын судалгааг хийлгэж, тухайн бүс нутаг, орчны унаган төлөв, нөхцөл байдлыг тодорхойлуулсны дээр тусгай хамгаалалттай газар нутаг, ойн ба усны сан бүхий газруудын хил заагтай давхцаж буй эсэх зэргийн талаарх лавлагааг авч ажилласан /Хавсралт 4/.<br><br>Хайгуулын ажил дууcч олборлолтын шатанд шилжих үеэс дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөг мэргэжлийн байгууллагын оролцоотойгоор орон нутаг, байгаль орчны хяналтын улсын байцаагчидтай зөвлөлдөн боловсруулж хэрэгжүүлэх юм. |

**Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт**

| Хийх ажил | Хариуцах | Баримтлах эрх зүйн орчин, шаардлага / тайлбар |
|---|---|---|
| Өрөмдлөгийн талбайн нөлөөллийн бүсэд оршин суух иргэдийг нүүлгэн шилжүүлэх шаардлага тогтоох | “Капкорп Монголиа” ХХК | Төслийн буюу нөлөөллийн бүсэд төслийн өмнөх үе шатны судалгааны үед орон нутгийн удирдлага, ард иргэдтэй уулзаж, тодруулсан ба нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох шаардлага гараагүй болно. |
| Шаардлагатай иргэдийг нүүлгэн шилжүүлж, нөхөн олговор олгох:<br>- Нүүлгэн шилжүүлэлт, нөхөн олговор шаардлагатай өрх болон үүнд хамрагдсан өрхийн тоо, хувиар | | |

# 4. ТҮҮХ СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ

| Хийх ажил | Хариуцах | Баримтлах эрх зүйн орчин, шаардлага / тайлбар |
|---|---|---|
| 1. Өрөмдлөг хайгуулын ажлын явцад түүх, соёлын дурсгалт зүйл болон археологи, угсаатан, палеонтологийн олдвор илэрвэл төслийн үйл ажиллагаа зогсоож, энэ тухай сум, дүүргийн засаг дарга, цагдаагийн байгууллагад болон холбогдох эрдэм шинжилгээний байгууллагад нэн даруй мэдэгдэнэ | “Капкорп Монголиа” ХХК | Газрын тосны хайгуулын “Онги V” талбайд байрлах түүх, соёлын дурсгалт зүйлс, археологи, палентологи, угсаатны зүйн олдворыг илрүүлэх, хамгаалах үүднээс ШУА-ын харьяа Түүх, Археологийн хүрээлэн, Плантеологи, Геологийн хүрээлэнгээр холбогдох судалгаа 2018 онд хийлгэж, хуулийн хэрэгжилтийг хангах, цаашид энэ чиглэлээр баримтлах арга зүйн зөвлөгөөг тус тус авч ажилласан болно. Үүнд:<br><br>1. “Капкорп Монголиа” ХХК-ий “Онги V” нэртэй газрын тосны хайгуулын тусгай зөвшөөрөлтэй талбай, Археологийн авран хамгаалах судалгааны тайлан”, Түүх, Археологийн хүрээлэн. 2018 он. - (22-31/III, 2018)<br>2. Газрын тосны хайгуулын Онги-V (Өвөрхангай аймгийн Баруунбаян-Улаан, Гучин-Ус, Төгрөг сумд)-н Палеонтологийн судалгааны ажил”, Палеонтологи, Геологийн хүрээлэн, 2015 он. - (21-31/V, 2015),<br>3. “Капкорп Монголиа” ХХК-ний Өвөрхангай аймгийн Нарийнтээл, Хайрхандулаан, Таргт, Төгрөг, Гучин-Ус, Баруунбаян-Улаан сумдын нутгийг хамрах газрын тосны Онги-V талбайд хийсэн “Угсаатны зүйн авран хамгаалах судалгааны ажлын тайлан”, Түүх, Археологийн хүрээлэн, 2018 он. - (22/III – 01/IV, 2018) |
| 2. Соёлын өвийн зааварчилгаа | | **Археологи -** Баруунбаян-Улаан сумын нутагт 47 T 721665.8 5002751.1 солбицолд орших өрөмдлөг хийх цэгт очиж шалгалт хийхэд ямар нэгэн дурсгал илрээгүй болно.<br>**Плантеологи -** “Онги-V” талбайн Өвөрхангай аймгийн Нарийн тээл, Баруунбаян улаан, Гучин ус, Богд, Төгрөг сумдын нутагт явуулсан палеонтологийн хайгуул судалгаа, ажиглалтын үр дүнд Баянтээгийн нүүрсний уурхайн орчимд тархсан юрын хурдсаас эртний ургамал, ургамлын үр тоосонцор, Таацын голын районд тархсан палеоген неогений хурдсаас эртний хөхтөн амьтны үлдвэр, Буйлстын худгийн доод цэрдийн хурдсаас үлэг гүрвэл, ургамлын үр тоосонцор, Андай худаг орчим тархсан доод цэрдийн хурдсаас ургамал, ургамлын үр тоосонцор, загас, Зүүн Хөөвөрөөс үлэг гүрвэл, хөхтөн, Ахар уулын орчмын доод цэрдийн хурдсанд эртний ургамлын үлдэгдэл тус тус олддог ба энэ удаагийн хайгуул судалгаагаар Буйлстын худаг, Зүүн Хөөвөр олдворт газруудаас үлэг гүрвэлийн ясны үлдэгдлийг олсон болно.<br>Дээрх олдворт газруудыг агуулсан уулархаг болон өндөрлөг газруудаас бусад палеонтологийн эрэл хайгуул хийсэн хөндий, голын сав газруудаар эртний амьтан ургамлын үлдэгдэл ажиглагдаагүй болно.<br>Иймд дээрх газруудыг хөндөхгүйгээр тусгай зөвшөөрөлтэй талбайд хайгуулын ажлыг гүйцэтгэх боломжтой гэж үзэж байна.<br>Цаашид хайгуулын ажлын явцад сонирхолтой үлдвэр илэрсэн тохиолдолд ШУА-ийн Палеонтологи, геологийн хүрээлэнд хандаж, “Соелын өвийг хамгаалах хууль”-ийн дагуу авран хамгаалах малтлага хийлгэх ажил зохион байгуулахыг санал болгож байна. |

| | | |
|---|---|---|
| | | **Угсаатны зүй** – Баруунбаян-Улаан сум. Монгол Алтайн нурууны үргэлжлэл Бага Богд, Арц Богдын уулсын хооронд завсар хөндий дагуу байрлах сум. Хангай, говь хосолсон зэрлэг амьтан элбэг байгалийн үзэсгэлэнт газар ихтэй. Жинст овоо, Бор овоо зэрэг тахилгат газруудтай. Өвөрхангай аймгийн Баруунбаян-Улаан, Гучин-Ус сумууд нь Сайн ноён хан аймгийн Сайн ноёны хошуунд хамаарагдаж байв. Дурдсан бүх сумд нь бүгд таван хошуу мал тэр дотроо тэмээ өсгөхөд нэн тохиромжтой говь, тал хээрийн бүс нутаг юм. Эндээс гарах дүгнэлт нь, говь нутгийн малчид иргэдийн ахуй соёлын онцлог, бэлчээр-усны асуудал, тахилгат онгон дагшин байдлыг хүндэтгэж үйл ажиллагаагаа явуулах нь уул уурхай, ашигт малтмал эрхэлдэг аж ахуйн нэгжүүдийн нийгмийн том үүрэг хариуцлагын нэг болохын хувьд компанийн зүгээс үйл ажиллагаа явуулахдаа иргэдийн үе дамжин шүтэж ирсэн овоодыг уул уурхайн үйл ажиллагааны нөлөөллөөс аль болох хол байлгах, говь-хээрийн бүсийн малчин айл өрхийн амьдралын хэв маяг, ёс заншил, газар усаа хүндэтгэх сэтгэлгээ зэргийг хүндэтгэн үзэж компанийн зүгээс шаардлагатай мэдээллээр байнга хангаж (ялангуяа усны), бэлчээр усны хохиролгүй гэсэн баталгааг тайлбарлан таниулж малчин өрх, компанийн хоорондын харилцан эерэг харилцаа бий болгож чадвал компанийн талаас монголын уламжлалт ахуй соёлыг хүндэтгэх, малчдын зүгээс улс орны бүтээн байгуулалт, үйл ажиллагааг дэмжих хоёр талын ач холбогдолтой тул энэ тал дээр анхаарч ажиллахыг зөвлөсөн байсан. |
| 3. Хайгуулын үеэр олдвор, үлдвэр илэрсэн тохиолдолд авран хамгаалах малтлага хийлгэх ажлыг зохион байгуулах | | Төслийн үйл ажиллагааны үеэр ямар нэг зүйл илрээгүй тул аль нэг мэргэжлийн байгууллагад хандаж, авран хамгаалах үйл ажиллагаа зохион байгуулах шаардлага гараагүй. |

# 5. ОСОЛ ЭРСДЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ

| **Урьдчилан сэргийлэх, хамгаалахаар төлөвлөсөн арга хэмжээ** | Хариуцах | Хэрэгжүүлсэн байдал |
|---|---|---|
| **Үүсэж болзошгүй байгалийн, биологийн болон технологийн гаралтай осол эрсдлээс урьдчилан сэргийлэхээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ** | | |
| Орон нутгийн иргэд болон талбай дээр ажиллаж буй ажиллагсдад тухайн бүс нутагт тохиолддог байгалийн гаралтай осол үүсэх нөхцөл байдлын талаарх мэдээлэл өгөх, энэ үед хувь хүн болон хээрийн ажлын үед авах арга хэмжээний талаарх зөвлөмж өгөх | Өрөмдлөгийн гэрээт гүйцэтгэгч, Капкорп Монголиа ХХК | Талбай дээр ажиллаж байсан нийт ажилчид, орон нутгийн иргэдэд төслийн талбайн бүс нутагт тохиолддог байгалийн гаралтай үүсэж болзошгүй осол эрсдлийн талаар танилцуулга мэдээлэл өгч, түүнээс хэрхэн сэргийлэх, тохиолдсон үед авах арга хэмжээний талаар заавар зөвлөмж өгч ажилласан.   |
| Төсөл хэрэгжих явцад тухайн бүс нутаг болон ОУ, Монгол улсыг хамарсан өвчлөл гарч байгаа эсэхэд байнга анхаарч, гарсан тохиолдолд урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах | Өрөмдлөгийн гэрээт гүйцэтгэгч, Капкорп Монголиа ХХК | Өрөмдлөгийн ажил үргэлжлэх хугацаанд улс орон нутгийн хэмжээнд биологийн гаралтай ямар нэгэн халдварт өвчин дэгдэлт гарч хориг хязгаар тавигдаагүй. |

Ажиллагсдыг хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгслээр бүрэн хангаж ажиллуулах



Code: PM-FRM-001 PPE Hand over sheet
Version: 2.0

PETROMATAD

Хүлээн авсан:
Received by: M. [illegible]
Шалгасан:
Checked by: [illegible]
Батласан:
Approved by:

НБХХ ОЛГОСОН МАЯГТ
HAND OVER SHEET

Огноо/Date: 2023, 6, 13

| No | Нэр/Description | Тоо ширхэг/Quantity | Үнэ/Price |
|---|---|---|---|
| 1 | Каск | 1 | |
| 2 | ажлын хувцас | 1+1 | |
| 3 | нүд/шил (тунгалаг) | 1 | |
| 4 | нүд/шил (хар) | 1 | |
| 5 | гутал | 1 | |
| 6 | савхин бээлий | 1 | |
| 7 | чихэвч | 1 | |
| | НИЙТ/ TOTAL х/утас | 1 | |
| | химийн/б бээлий | 1 | |

| № | | Олгосон/issued by | Хүлээн авсан/ Received by |
|---|---|---|---|
| 1 | Зориулалт/intended use | Block V VR1 | PPE |
| 2 | Ажилтны нэр/Employee name | Нарангэрэл | |
| 3 | Албан тушаал/Position | ХАБЭА ажилтан | [illegible] |
| 4 | Утасны дугаар/Phone number | 99904956 | |
| 5 | Гарын үсэг/ Signature | [illegible] | M. [illegible] |

Талбай дээр өрөмдлөгийн ажил явагдах хугацаанд ажилчдад хувийн хамгаалах хэрэгсэлийг ажил үүргийн хуваарьт заагдсан ажил үүрэгтэй уялдуулан хангаж байсан. Ажилчдын нэг бүрийн хамгаалах хувцас хэрэгслээр хангаж, тус бүр хүлээлгэн өгч гарын үсэг зуруулан бүртгэл хийж байсан.



Өрөмдлөгийн гэрээт гүйцэтгэгч Мэжор Дриллинг ХХК нь мөн өрмийн талбай дээр ажиллаж байгаа нийт инженер техникийн ажилчиддаа хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгслээр бүрэн хангаж ажилласан.



| | | |
|---|---|---|
| Хөдөлмөр хамгаалал болон болзошгүй осол, аюулаас урьдчилан сэргийлэх, осол аваарын үед авах арга хэмжээний төлөвлөгөө гарган цаг үеийн байдалтай уялдуулан тодотгол хийж, ажиллагсдад энэ үед хэрхэн ажиллах талаар мэдээлэл сургалт хийх | | Компани ажилчдын дотоод сургалтын төлөвлөгөөг гаргаж батлуулан ажилчдыг болзошгүй осол, аюулаас урьдчилан сэргийлэхэд шаардлагатай сургалтуудыг тогтмол хийдэг. Үүнд: шинээр ажилчд орж байгаа ажилтнуудад хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хүрээнд зайлшгүй шаарлагатай сургалт, нийт ажилчдын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалт, эрүүл мэндийн эргономик, гар ажиллагаа, алжаал ядаргаа хянах, сэтгэцийн эрүүл мэнд сургалтуудыг зохион байгуулдаг. Мөн түүнчлэн өндөр эрсдэлтэй ажлын байрны сургалтууд болох H2S, аюулгүйн жолоодлого, химийн бодистой харьцах ажилтны сургалтууд, анхны тусламж үзүүлэх сургалтуудыг нийт ажилчид болон шаардлагатай ажилтнуудад явуулсан байна.<br><br>Галын аюулгүй байдлын сургалт<br><br>Галын аюулгүй байдлын практик сургалт |



"НОМГОН САНЧИР ГРУПП"ХХК

АЮУЛГҮЙ ЖОЛООДЛОГО АМЬДРАЛЫН БАТАЛГАА

СУРГАЛТЫН ТАЙЛАН

(Петро Матад ХХК)

УЛААНБААТАР ХОТ

2022 он

Аюулгүйн жолоодлогын сургалтанд жолооч нарыг хамрагдсан байдал-тайлан



Яам, агентлаг: АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОС
Байгууллага: ПЕТРО МАТАД ХХК

ҮНЭМЛЭХ № ПМ/2022/06

Тэгшжаргал овогтой БАТБИЛЭГ
Албан тушаал: Геологич

Хөдөлмөр нийгмийн хамгааллын яам, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төвийн олгосон аюулгүй ажиллагааны сургалтын байгууллагын 17100344 тоот гэрчилгээтэй **ХЭРЛЭН ЭРДЭС ХИМИ ХХК**-ны дэргэдэх **МОНГОЛЫН УР ЧАДВАР** сургалтын төвд "Химийн бодисын аюулгүй ажиллагаа"-ны сургалтанд суралцаж амжилттай төгсөв.

Сургалт хариуцсан захирал Ц.Сүнжидмаа

Олгосон 2022 оны 05 дугаар сарын 31-ны өдөр

Химийн бодисын аюулгүй ажиллагааны дүрэм

| № | Сургалтын агуулга | Үнэлгээ |
|---|---|---|
| 1 | Химийн бодисын ашиглах, ХХХ | 92% |
| 2 | Химийн бодисын хадгалах, ХАЛМ | |
| 3 | Химийн бодисын тээвэрлэлт | |
| 4 | Химийн бодисын устгал | |
| 5 | Химийн бодисын үеийн анхан шатны тусламж | |

Дараагийн шалгалт өгөх хугацаа 2025.05.31

ХАБЭА-н менежер

Б.Шинебаяр

Яам, агентлаг: АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОС
Байгууллага: ПЕТРО МАТАД ХХК

ҮНЭМЛЭХ № ПМ/2022/01

Сүхрагчаа овогтой НАРАНЖАРГАЛ
Албан тушаал: ХАБЭА-н ажилтан

Байгаль орчныг хамгаалах ажилд зориулан 150,352,000 төгрөг төлөвлөснөөс нөхөн сэргээлтийн барьцаа хөрөнгийн дансанд өмнөх хайгуулын ажлын үе шатанд байршуулсан 88,377,550 сая төгрөг байршуулсан, бусад төлөвлөгөөт арга хэмжээний хүрээнд нийт 154,340,000 төгрөг буюу 100% гүйцэтгэлтэй гарав.

Мөн, ажилчдын эрүүл мэндийн үзлэг, хяналтыг тогтмол хийж ирсэн ба “БОМТ-2023”-д тусгасан нийт 11 бүлгийн 60 гаруй ажлыг энэхүү тайлант хугацаанд амжилттай хийж гүйцэтгэв.

**Велосираптор-1 цооногийн өрөмдлөгийн ажлын хүрээнд орон нутгийг дэмжих, нийгмийн хариуцлагийн хүрээнд хийгдсэн ажил**

Капкорп Монголиа ХХК-ниас энэ онд өрөмдсөн Велосираптор цооногийн өрөмдлөгийн ажлын хүрээнд Өвөрхангай аймгийн Гучин-Ус, Баруунбаян-Улаан сумдад орон нутгийг дэмжих ажлууд, төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлсэн байна. Эдгээр ажлууд нь компаний орон нутгийг дэмжих сангаас санхүүжүүлэгддэг. Үүнийг доор дэлгэрүүлье.

1. Гучин-Ус сумын 2-р сургуулийн анги танхим, тэр дундаа физикийн танхим, номын санд орчин үеийн электрон ухаалах самбар дэлгэц, сурагчийн ширээ сандал, проектор, ангид шкаф, багшийн ширээ зэргээр бүрэн тохижуулсан. Нийт санхүүжилт нь 55,845,800 төгрөг.








Ухаалаг дэлгэцээр ангиудыг тохижуулсан байдал



Физикийн анги танхимыг ширээ сандалаар тохижуулсан байдал



Шкаб, паркетан шал



Номын сангийн тохижилт

2. Баруунбаян-Улаан сум, Гучин-Ус сумдын нутагт бэлчээрийн усан хангамжийг нэмэгдүүлэх зорилгоор 2 гүний худаг гаргасан. Нийт санхүүжилт 70,000,000 төгрөг.





Гучин-Ус суман дахь худаг





Баруунбаян-Улаан суман дахь худаг

# ХАВСРАЛТ

Хавсралт 1. Улсын бүртгэлийн гэрчилгээ

УБ-2

Монгол Улсын Засгийн газрын
2004 оны 20 дугаар тогтоолоор батлав.

# МОНГОЛ УЛС
# УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ

2006.08.15
/Бүртгэсэн он, сар, өдөр/

9019014069
/Улсын бүртгэлийн дугаар/

5077982
/Регистрийн дугаар/

Си Эй Пи Си ХХК - Гадаадын хөрөнгө оруулалттай
/Хуулийн этгээдийн нэр, хариуцлагын хэлбэр/

Дүрэм
/Үүсгэн байгуулах баримт бичиг/

Тушаал
/шийдвэрийн нэр/

А-2464
/дугаар/

2006.08.14
/он, сар, өдөр/

511000 /код/

Гадаад худалдаа
/Үндсэн эрхлэх үйл ажиллагааны чиглэл/

/код/

/Туслах эрхлэх үйл ажиллагааны чиглэл/

1
хугацаа

1
/гишүүдийн тоо/

11,600.0
/өөрийн хөрөнгийн хэмжээ, мянган төгрөгөөр/

Баянзүрх, 1-р хороо, 12-р хороолол, Нисора цамхаг - 902, утас1:463763, утас2:463761, факс:
/хуулийн этгээдийн албан ёсны хаяг/

ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ГАЗАР ҮНДЭСНИЙ
УЛСЫН БҮРТГЭЛИЙН АЛБА
УХА0175

Улсын бүртгэлийн алба
/Бүртгэсэн байгууллагын нэр/

Хавсралт 2. Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл

МОНГОЛ УЛС
УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ

# АЖ АХУЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ

20 21 оны 09 сарын 09 өдөр     Дугаар 736     Улаанбаатар хот

| | |
|---|---|
| *Эрхлэх үйл ажиллагааны төрөл* | Газрын тос хайх |
| *Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нэр* | "Капкорпмонголиа" ХХК |
| *Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хаяг* | Улаанбаатар, Сүхбаатар, 1-р хороо, Энхтайвны өргөн чөлөө 17, Блю Скай Тауэр, 508 тоот |
| *Регистрийн дугаар* | 5077982 |
| *Тусгай зөвшөөрлийн хугацаа* | 2 /хоёр/ жил. 2023.07.29 хүртэл |

*Тусгай нөхцөл, шаардлага*

Холбогдох хууль, дүрэм, журмын хэрэгжилтийг хангаж, Газрын тосны тухай хууль, Бүтээгдэхүүн хуваах гэрээгээр хүлээсэн үүрэг болон тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үүргээ биелүүлж ажиллах.

*Монгол Улсын Уул уурхай, хүнд үйлдвэрийн Сайдын 202 1 оны 09 сарын 09 өдрийн А/242 дугаар тушаалыг үндэслэн олгов.*

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ГИШҮҮН,
УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН САЙД     Г.ЕНДОН

Хавсралт 3. Газар ашиглах зөвшөөрөл

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
БАРУУНБАЯН-УЛААН СУМЫН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2022 оны 05 сарын 11 өдөр Дугаар а/60 Баруунбаян-Улаан сум

Гэрээ байгуулан хяналт тавьж ажиллах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.13, 59.1.16, 59.1.18, 66 дугаар зүйлийн 66.1, Газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.2, Газрын тосны тухай хууль 10 дугаар зүйлийн 10.1.1, 10.3.1 дэх заалт, Засгийн газрын 2022 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн хуралдааны 25 дугаар тэмдэглэлийн шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Монгол Улсын засгийн газрын 2009 оны 07 дугаар сарын 20-ны өдрийн 235 дугаар тогтоолоор байгуулагдсан бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу хайгуулын “ОНГИ V” талбайд газрын тосны хайгуулийн өрөмдлөгийг 3 сарын хугацаатай хийж хуулийн хүрээнд үйл ажиллагаа явуулахыг “Капкорп Монголиа” ХХК болон туслан гүйцэтгэгч компанид зөвшөөрсүгэй.

2.Дээрхи ажлын хүрээнд хээрийн анги байрлах газар болон зам ашиглалтанд зөвшөөрөл олгосугай.

3.Хог хаягдал, технологийн болон ундны усны ашиглалтын гэрээг холбогдох хууль, тогтоомжийн дагуу байгуулан үйл ажиллагаа явуулах хугацаанд хяналт тавьж ажиллахыг Байгаль орчны хяналтын улсын байцаагч (Б.Даваадавга)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА Д.БААТАРЧУЛУУН

622211128

D/My doc alban bichig Zahiramj A4.doc

Хавсралт 4. Гол мөрний урсац бүрэлдэх эх, ойн сан бүхий газрын хилийн заагтай давхцалгүй болох тухай лавлагаа

МОНГОЛ УЛСЫН
БАЙГАЛЬ ОРЧИН,
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Нэгдсэн Үндэстний гудамж 5/2, Засгийн газрын II байр
Утас: 26 19 66, Факс: (976-51) 26 61 71,
И-мэйл: contact@mne.gov.mn, Вэбсайт: www.mne.mn

2022.06.07 № 06/3178

танай ____________-ны №____________-т

"КАПКОРП МОНГОЛИА" ХХК-НЫ
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
А.ГЭРЭЛТ-ОД ТАНАА

Танай компаниас ирүүлсэн 018/022 тоот албан бичигт дурдсан өрөмдлөгийн талбай нь Засгийн газрын 2012 оны 194 дүгээр тогтоолоор баталсан Гол мөрний урсац бүрэлдэх эх, ойн сан бүхий газрын хилийн зааг, Засгийн газрын 2015 оны 289 дугаар тогтоолоор баталсан Усны сан бүхий газрын энгийн хамгаалалтын бүстэй тус тус давхцалгүй байна.

Зурган мэдээллийг хавсаргав.

Хавсралт 1 хуудастай.

ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧИН,
БАЙГАЛИЙН НӨӨЦИЙН
УДИРДЛАГЫН
ГАЗРЫН ДАРГА А.ЭНХБАТ

БАЙГАЛЬ ОРЧИН, НОГООН ХӨГЖЛИЙН ЯАМ

**ЛАВЛАГАА**

**"КАПКОРП МОНГОЛИА" ХХК**




**Таних тэмдэг**

**Гадаргын ус**

Гол

Түр урсацтай гол

Нуур

**Хамгаалалтын бүсүүд**

**Засаг захиргааны хил**

Аймгийн төв

Сумын төв

**Улсын ТХГН -ийн сүлжээ**

МАСШТАБ1:8,750

**ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧИН, БАЙГАЛИЙН НӨӨЦИЙН ГАЗАР**

**Ой, ус, тусгай хамгаалалттай газрын кадастрын хэлтэс**

Засгийн газрын 2012 оны 194, 2015 оны 289-р тогтоолоор батлагдсан гол, мөрний урсац бүрэлдэх эх, ойн сан бүхий газар, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, орон нутгийн усны энгийн болон онцгой хамгаалалтын бүстэй тус тус давхцалгүй байна.

Боловсруулсан: мэргэжилтэн Х.Номин / /

Огноо: 6/6/2022

Хавсралт 5. Байгаль орчны барьцаа хөрөнгө байршуулсан тооцооны үлдэгдлийн баталгаа

**НХМаягт Т-3**

Санхүү, эдийн засгийн сайд, Үндэсний статистикийн газрын даргын 2002 оны тоот тушаалын хавсралт

**ТООЦООНЫ ҮЛДЭГДЛИЙН БАТАЛГАА №**

**Нэхэмжлэгч:**
Байгууллагын нэр: Байгаль Орчин Аялал Жуулчлалын Яам

Хаяг: Улаанбаатар 15160, Чингэлтэй дүүрэг Нэгдсэн үндэстний гудамж 5/2, Засгийн газрын II байр

Утас, факс: (976-51) 261966
Э-шуудан:________________________________
Банкны нэр: БО нөхөн сэргээх баталгаа
Банкны дансны дугаар: 100900013406

**Төлөгч:**
Байгууллагын нэр: Капкорп Монголиа ХХК

Хаяг: Улаанбаатар 15000, Сүхбаатар дүүрэг 1-р хороо, Блью скай тауэр, 508

Утас, факс: 70141099
Э-шуудан:______________________
Банкны нэр: Капкорп Монголиа ХХК
Банкны дансны дугаар: 5003 245 443

ТООЦОО НИЙЛСЭН ДАНСНЫ №

Нэхэмжлэгчийн нэрийн өмнөөс ерөнхий нягтлан бодогч ажилтай Оюунчимэг нь төлөгчийн нэрийн өмнөөс нягтлан бодогч ажилтай Ширдорж овогтой Мөнхнарантай тус хоёр байгууллага хооронд 2015 оны 01 сарын 01 өдрөөс 2022 оны 05 сарын 04 өдрийг дуустал хугацаанд өгч авалцсан зүйлээ хоёр байгууллагад хөтлөгдөж буй нягтлан бодох бүртгэлийн дэлгэрэнгүй ба хураангуй бүртгэлийн бичилтээр нэг бүрчлэн нийлж үзэхэд Капкорп Монголиа ХХК нь БО нөхөн сэргээх баталгааны 100900013406 тоот дансанд 88,377,550 төгрөг (наян найман сая гурван зуун далан долоон мянга таван зуун тавин төгрөг 00 мөнгө) төлж байршуулсан нь үнэн болохыг харилцан батлав.

(Тэмдэг) Нэхэмжлэгч байгууллагын нягтлан бодогч Л. Оюунчимэг / 2022.04.18.

(Тэмдэг) Төлөгч байгууллагын нягтлан бодогч Ш. Мөнхнаран, / 2022.05.09 хүлээж авсан.

Хавсралт 6. Ус ашиглах боломжит нөөцийн дүгнэлт

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
УСНЫ ГАЗАР
Чингүнжавын гудамж, 2 дугаар хороо,
Баянгол дүүрэг, Улаанбаатар хот, 16050
Утас/Факс: (976-51) 26 55 78, (976-51) 26 55 36,
Цахим шуудан: office@water.gov.mn,
Цахим хуудас: www.water.gov.mn

2023.05.05 № 01/595
танай 2023.04.21-ны № 038/023-т

"КАПКОРП МОНГОЛИА" ХХК–Д

"Усны тухай" хуулийн $16^{1}$.4.10 дахь заалтыг үндэслэн Өвөрхангай аймгийн Баруунбаян-Улаан сумын нутагт танай компанийн хэрэгжүүлэх "Газрын тосны хайгуулын цооног өрөмдөх" төслийн ус хангамжийн эх үүсвэр өөрчлөгдсөнтэй холбогдуулан байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлан, холбогдох бусад материалыг судлан үзээд усны ашиглах боломжит нөөцийн дүгнэлтийг дахин гаргаж хавсралтаар хүргүүлж байна.

Хавсралт: 2 хуудастай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Я.БОЛДБААТАР

162331275

## УСНЫ АШИГЛАХ БОЛОМЖИТ НӨӨЦИЙН ДҮГНЭЛТ

2023 оны 05 дугаар сарын 05-ны өдөр

Дугаар-.65

Улаанбаатар хот
Утас: 51-265526, 265528

**1. Төсөл хэрэгжүүлэгч аж ахуйн нэгж, байгууллага:**
"Капкорп монголиа" ХХК, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Ерөнхий сайд Амарын гудамж, "НИК" ХК-ий байр, 406-407 тоот. Улсын бүртгэлийн дугаар: 9019014069, Регистрийн дугаар: 5077982. Утасны дугаар: 331099, 321799

**2. Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ боловсруулсан аж ахуйн нэгж, байгууллага:**
"Эконатур" ХХК,

**3. Төслийн нэр, байршил:**
"Газрын тосны хайгуулын цооног өрөмдөх" төсөл нь Өвөрхангай аймгийн Баруунбаян-Улаан сумын нутагт хэрэгжих бөгөөд Таац голын сав газарт хамаарна.

**4. Тусгай зөвшөөрлийн дугаар, үйлдвэрлэл, үйлчилгээний нэр, төрөл, зориулалт:**
Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны 2021 оны 09 сарын 09-ний өдрийн 736 дугаартай аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөлтэй.

**5. Төслийн хүчин чадал, ажиллах горим:**
Төсөл нийт 1 жилийн хугацаанд хэрэгжих бөгөөд жилд 6,000.0 тууш метр өрөмдөхөөр төлөвлөсөн. Төсөлд 80 ажилтан, жилд 120 хоног ажиллана.

**6. Усны эх үүсвэр, байршил:**
Төслийн усны хэрэглээг 2018 онд Гучин-ус сумын Аргалант багт гаргасан өөрийн эзэмшлийн гүний худгаас хангана. Худгийн байршил 101° 50' 0.75", 45° 10' 25.19", ундарга 3.0 л/сек.

**7. Ашиглах усны хэмжээ:**
Төслийн жилийн усны хэрэглээг БОНХАЖ-ын Сайдын 2015 оны А/301 дүгээр тушаалаар баталсан "Нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэхэд зарцуулах усны норм"-оор тооцоход:

Ажилчдын ундны усны хэрэглээ:
80 хүн x 30 л/хон = 2.4 м³/хон (288.0 м³/жил);

Өрөмдлөгийн ажлын технологид:
Шавар уусмал хэрэглэн өрөмдөхөд 43 м³ x 60 хон = 2,580.0 м³/жил;

Туршилтын ажлын технологид: Нэг цооногт 3 давхар туршилт хийхэд (өрөмдлөгийн хайгуул хийж гүйцэтгэсний дараа туршилт хийгдэх эсэх тодорхойлогдоно)
74 + 3 x 36 + 3 x 4 = 192 x 2 (нийт 2 цооног) = 388.0 м³/жил (12.93 м³/хон)

Шингэн хагалбарын ажлын технологид: (өрөмдлөгийн хайгуул хийж гүйцэтгэсний дараа шингэн хагалбар хийгдэх эсэх тодорхойлогдоно)
2 x 1,470.0 м³ = 2,940.0 м³/жил (жилд 39 хоног ажиллана);

Зам талбайн тоосжилт дарах усалгаанд:
5,000.0 м² x 2 л = 10.0 м³/хон x 12 (жилд услах хоногийн тоо) = 120.0 м³/жил;

**Нийт усны хэрэглээ 143.71 м³/хон (6,316.0 м³/жил)**

***8. Дүгнэлт:***
Төсөл хэрэгжүүлэхэд шаардагдах ажилчдын унд ахуй, технологи, туршилтын технологи, зам талбайн усалгааны 143.71 $м^3$/хон усны хэрэглээг 3.0 л/сек (259.2 $м^3$/хон) ундаргатай гүний худгаас хангахад усны ашиглах боломжит нөөцийн хэмжээ **хүрэлцээтэй** байна.

***9. Тавих шаардлага, цаашид авах арга хэмжээ, зөвлөмж:***
-Төслийг хэрэгжүүлэхдээ "Усны тухай" хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2, 24.4, 28 дугаар зүйлийн 28.4, 28.9, 30 дугаар зүйлийн 30.1 дэх заалтуудын хэрэгжилтийг хангаж ажиллах;
-Төслийн ус хангамжийн эх үүсвэрт ашиглах худгийн мэдээллийг Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланд тусгахыг "Капкорпмонголиа" ХХК-д зөвлөж байна.

УСНЫ НӨӨЦИЙН
ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН Б.МӨНГӨНТУУЛ

Хавсралт 7. Ус ашиглуулах дүгнэлт

**БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР**
**ДҮГНЭЛТ**

Нутгийн удирдлагын ордон, П.Гэндэнгийн гудамж,
5 дугаар баг, Арвайхээр сум, Өвөрхангай аймаг, 62173,
Утас: (976) 7032 3260,
Цахим шуудан: Uvurkhangainature@gmail.com
Цахим хуудас: www.Uvurkhangai-baigal orchin.com

2023.05.12 № 03/05

танай 2023.04.25-ны № 040/023 -т

"КАПКОРП МОНГОЛИА" ХХК

Ус ашиглуулах дүгнэлт хүргүүлэх тухай

1. **Аж ахуйн нэгж байгууллага, захирлын нэр, хаяг, утас, факс, улсын бүртгэлийн дугаар болон регистрийн дугаар:** "Капкорп Монголиа" ХХК, улсын бүртгэлийн дугаар 9019014069, регистрийн дугаар 5077982, гүйцэтгэх захирал А.Гэрэлт-Од, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Энхтайваны өргөн 17, Блюскай Тауэр, 508 тоот. Улсын бүртгэлийн дугаар 9019014069, реистрийн дугаар: 5077982. Утасны дугаар: 331099, 321799
2. **Төслийн байршил, харъяалагдах сав газар:** Өвөрхангай аймгийн Баруунбаян-Улаан сумын нутаг, Таац голын сав газар.
3. **Төсөл хэрэгжүүлэгч:** "Капкорп Монголиа" ХХК
4. **Тусгай зөвшөөрлийн дугаар болон талбайн хэмжээ, координат /Х,У/:** Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны 2021 оны 09 сарын 09-ний өдрийн 736 дугаартай аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөлтэй. Цооногт шингэн хагалбар хийх тохиолдолд өрөмдлөгийн үед ашиглагдаж байсан 150м х 200м буюу 3 га талбай/2 өрөмдлөг адил хэмжээний газрын хуваарилалттай тул үндсэндээ 6 га талбай хамрагдана,

| | |
|---|---|
| $101^0$ 75' 078" | $45^0$ 11' 918" |
| $101^0$ 75' 282" | $45^0$ 06' 313" |
| $101^0$ 89' 685" | $45^0$ 12' 174" |
| $101^0$ 87' 456" | $45^0$ 06' 584" |

5. **Үйлдвэрлэл, үйлчилгээний нэр төрөл, зориулалт:** Газрын тосны хайгуул, судалгааны ажил.
6. **Үйлдвэрийн техник, технологи, ажиллах горим, хүчин чадал:** Өрөмдлөгийн ажилд өрмийн цамхаг, титэм блок, өргөх төхөөрөмж, вертлюк сальник, ротарын тавцан зэрэг тоног төхөөрөмж ашиглана. Нийт 80 хүний бүрэлдэхүүнтэйгээр 60 хоногийн хугацаанд 2 цооног өрөмдөх ба өрмийн цамхагийг буулгах, зөөвөрлөх, буцаан барих зэрэг нэг цооногоос нөгөөд шилжих хугацаа 60 хоногт, нийт 120 хоногийн хугацаанд цооног өрөмдлөгийн ажил явагдана.
7. **Үйлдвэрлэх, боловсруулах бүтээгдэхүүний хэмжээ:** Ордыг ашиглалтанд бэлтгэх зорилгоор өрөмддөг, хайгуулын цооногоос ордын горимын үзүүлэлтүүд, агуулагч чулуулгийн шинж чанар, давхаргын нефть, хий, усны шинж чанар зэргийг тодорхойлох зорилгоор ашигт үе давхаргаас гулууз дээж авна.
8. **Усны эх үүсвэр, нөөц, хоногт ашиглах хэмжээ:** Төслийн усны хэрэглээг 2018 онд Гучин-Ус сумын Аргалант багт гаргасан $101^0$ 50' 0,75" $45^0$ 10' 25,19" цэгт байрлах гүний худгаас хангана. Усны газрын 2023 оны 05 сарын 05-ны өдрийн 65 дугаартай усны ашиглах боломжит нөөцийн дүгнэлтийг хайгуулын үйл ажиллагаанд хоногт 143,71 $м^3$/хон ашиглахад хүрэлцээтэй гэж үзсэн байна.
9. **Усны барилга байгууламжууд /нэр, хүчин чадал, хэмжээ, хийц, дамжуулах шугам сүлжээний урт, диаметр/:**

10. **Худаг, өргөлтийн станцууд, усны тоолуур /насосны хүчин чадал, марк/:** Тоолуур суурилуулаагүй.

11. **Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ, нөхцөл:** Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлан 2022 онд "Эко натурл" ХХК-р хийлгэсэн.

**Дамжуулах байгууламж /шугам сүлжээний урт, диаметр/:** Гүний усны машинаар зөөврлөн ашиглана.

12. **Онцгой нөхцөл:** Цэвэр, бохир ус шугамнаас шүүрэлтээр алдагдахаас сэргийлэх, хяналт байнга тавих.

13. **Холбогдох хууль, дүрэм, журам, норм стандартын дагуу усны зарцуулалтыг тооцох:**

- Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайдын 2015 оны 07 дугаар сарын 30-ны өдрийн А/301 дугаар тушаалаар батлсан "Нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэхэд зарцуулах усны түр норм"-оор тооцоход:

Ажилчдын унд, ахуйд:
245 хүн x 20 л/хон =4,9 $м^3$/хон * 60 хон = 294,0 $м^3$/жил

Өрөмдлөгийн ажлын технологид:
43,0 $м^3$ x 60 хон = 2580,0 $м^3$/жил

Туршилтын ажлын технологид:
37 + 3 x 27 +3 x 4 = 130 x 2 цооног = 260,0 $м^3$/жил

Шингэн хагалбарын ажлын технологид:
2 x 350,0 $м^3$ =700,0 $м^3$/жил

Олборлолтын туршилтын үед:
2 x 15 = 30,0 $м^3$/жил

Зам талбайн тоосжилт дарах усалгаанд:
2500,0 x 2 л = 5,0 $м^3$/хон x 12 (услах хоногийн тоо) = 60,0 $м^3$/жил

**Нийт усны хэрэглээ:**
294,0 + 2580,0 + 260,0 + 700,0 + 30,0 + 60,0 = 3924,0 $м^3$/жил ус шаардлагатай байна.

14. **Холбогдох хууль, тогтоол шийдвэрийн дагуу оногдуулах усны нөөцийн төлбөрийг урьдчилсан байдлаар тооцоход:** Үйлдвэрлэлийн хэрэгцээнд ашиглах **3924,0 $м^3$** усны төлбөрийн хэмжээг Засгийн газрын 2011 оны 302 дугаар тогтоолоор Онги голын сав газарт тогтоосон газрын доорх усны экологи-эдийн засгийн суурь үнэлгээ, "Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай" Засгийн газрын 2013 оны 327 дугаар тогтоолд заасан ашиглалтын зориулалтыг тооцох итгэлцүүр, "Усны нөөц ашигласны төлбөрийн хувь хэмжээг тогтоох, хөнгөлөх тухай" Засгийн газрын 2013 оны 326 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар тогтоосон усны нөөц ашигласны төлбөрийн хувь, хэмжээг ашиглан тооцож, тогтоосон хэмжээгээр "Төсвийн тухай" хуулийн 23.6.5-д заасны дагуу ус ашиглах гэрээнд заасан хугацаанд аймгийн төсөвт төвлөрүүлэх нь зүйтэй.

15. **Үйлдвэрлэл, үйлчилгээнд усны нөөцийг хэмнэх эргүүлж ашиглах даалгавар:** Усны нөөцийг хэмнэх зүй зохистой ашиглах үүднээс усыг дахин ашиглах дэвшилтэт технологийг судалж нэвтрүүлэх. Усны алдагдлыг багасгах зорилгоор шугам хоолой болон хаалт, насосын үзлэг, үйлчилгээг тогтмол хийж байх.

16. **Тавигдах шаардлага, цаашид авах арга хэмжээний талаарх зөвлөмж**

- Энэхүү дүгнэлтийг үндэслэн Усны тухай хуулийн 13.1.5-д заасны дагуу Гучин-Ус сумын Засаг даргаас ус ашиглах зөвшөөрөл авах;
- Мөн хуулийн 19.1.4-д заасны дагуу Гучин-Ус сумтай ус ашиглах гэрээ байгуулж, эрхийн бичиг авч, гэрээг аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газарт бүртгүүлэх;
- Ус ашиглах зөвшөөрөл, гэрээнд заасан хэмжээнээс хэтрүүлэн ашиглахгүй байх;

- Хаягдал ус хаях, зайлуулах зөвшөөрөл авах, төвлөрсөн ариутгах татуургын сүлжээнд нийлүүлэх;
- Усны нөөц ашигласны болон ус бохирдуулсны төлбөр төлөх;

ХЯНАСАН: ДАРГА Г.БАЯСГАЛАН

ДҮГНЭЛТ ГАРГАСАН: УСНЫ НӨӨЦИЙН АШИГЛАЛТ, ХАМГААЛАЛТЫН АСУУДАЛ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН Б.ЭНХСҮРЭН

Хавсралт 8. Ус ашиглах зөвшөөрөл, гэрээ

**ӨВӨРХАНГАЙ АЙМАГ**
**ГУЧИН-УС СУМЫН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2023 оны 05 сарын 17 өдөр Дугаар А/73 Гучин-Ус сум

Ус ашиглах зөвшөөрөл олгож
гэрээ байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Усны тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.5, 28 дугаар зүйлийн 28.6, 29 дүгээр зүйлийн 29.1 дэх хэсэг, аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2023 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн 03/03 дугаартай дүгнэлтийг тус тус үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ** нь:

1."Капкорн Монголиа" ХХК-ийн хайгуулын өрөмдлөгт зориулж 45⁰10'13.58"N; 101⁰57'38,29"E солбилцол бүхий худгаас ус ашиглах зөвшөөрөл олгосугай.

2."Капкорн Монголиа" ХХК-тай ус ашиглах гэрээ байгуулан, эрхийн бичиг олгон бүртгэж, мэдээллийн сав газрын захиргаа, аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газарт хүргүүлж ажиллахыг Байгаль орчны хяналтын улсын байцаагч (М.Долгорсүрэн)-д үүрэг болгосугай.

3.Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Байгаль орчны хяналтын улсын байцаагч (М.Долгорсүрэн)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА Х.ЭНХТАЙВАН

My doc.D.Zahiramj

**УС АШИГЛАХ ГЭРЭЭ**

2023 оны 05 сарын 12-ний өдөр №  Гучин-Ус сум

Усны тухай Монгол Улсын хуулийн 19, 20 дугаар зүйл, Өвөрхангай аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2023 оны 5 дугаар сарын 12-ны өдрийн 03/03 тоот ус ашиглуулах дүгнэлт, ус ашиглах зөвшөөрлийг үндэслэн Ус ашиглуулагчийг төлөөлж Өвөрхангай аймгийн Гучин-Ус сумын Засаг дарга Х. Энхтайван, Ус ашиглагчийг төлөөлж "КАПКОРП МОНГОЛИА" ХХК-ийн Гүйцэтгэх захирал А.Гэрэлт-Од нар ус ашиглах талаар тохиролцон энэ гэрээг байгуулав.

**Гэрээний нөхцөл:**

1. **Ус ашиглах зориулалт:**

   Газрын тосны хайгуулын өрөмдлөг

2. **Ашиглах усны хэмжээ:**

   а/ Ахуйн зориулалтаар: 245 хүн x 20л/хон = 4,9 $м^3$/хон x 60 хон = 294.0 $м^3$

   б/ Өрөмдлөгийн ажлын технологид:

   43.0 $м^3$ x 60 хоног= 2580.0 $м^3$ /жил

   в/ Туршилтын технологи

   37+3x27+3x4=130x2 цооног=260,0 m3/жил

   Шингэн хагалбарын ажлын технологид:

   2x350,0m3=700,0m3/жил

   Олборлолтын туршилтын үед:

   2x15=30,0m3/жил

   Зам талбайн тоосжилт дарах усалгаанд:

   2500,0x2л=5,0m3/хоног X12(услах хоногийн тоо)=60,0 m3/жил

   Нийт усны хэрэглээ:

   294,0+2580,0+260+700+30+60=3924,0 m3/жил ус шаардлагатай байна.

3. **Ус ашиглах гэрээний хугацаа:**

   а/ эхлэх 2023 он 05 дугаар сарын 15 өдөр

   б/ дуусах 2024 он 05 дугаар сарын 15 өдөр

4. **Усны эх үүсвэрийн байршил, барилга байгууламж, тоног төхөөрөмж, тэдгээрийн хүч чадал, төсөвт өртөг, ус хэмжих хэрэгслийн нэр, төрөл, тоо:**

   Өвөрхангай аймгийн Гучин-Ус сумын 3 дугаар багт байрладаг. Худгийн байргүй, насосны марк 7 квт, 8-10 тн.

5. **Усны эх үүсвэрийн төлөв байдал, найрлага, чанар:** Гүний худаг, цэнгэг

6. **Бохир ус зайлуулах цэг**: Байхгүй

7. **Ус ашигласны төлбөр:**

| Д/д | Ус ашиглалтын төрөл | [1]Экологи эдийн засгийн суурь үнэлгээ төгрөг/шоо метр/ | [2]Ус ашигласны төлбөрийн хувь хэмжээ /20%/ | [3]Ашиглалтын зориулалтыг тооцох итгэлцүүр / | 1 $м^3$ усны үнэ/төг |
|---|---|---|---|---|---|
| 1 | Ахуйн хэрэглээний ус | 1939 | - | 0.5 | 969.5 |
| 2 | Технологийн хэрэглээний ус | 1939 | 0.2 | 2.1 | 3,255.0 |

[1] Засгийн газрын 2011 оны 302 дугаар тогтоолоор Тааш голын сав газар тогтоосон газрын доорх усны суурь үнэлгээ

[2]Усны нөөц ашигласны төлбөрийн хувь хэмжээг тогтоох, хөнгөлөх тухай" Засгийн газрын 2013 оны 326 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар тогтоосон усны нөөц ашигласны төлбөрийн хувь, хэмжээ

[3] Тогтоолын хавсралтад өөрчлөлтөд оруулах тухай Засгийн газрын 2013 оны 327 дугаар тогтоолд заасан ашиглалтын зориулалтыг тооцох итгэлцүүр/газрын доорх усанд/

**а/ ахуйн хэрэглээнд:** Тааш голын сав газарт дээрх хүснэгтэд дурьдсан төлбөрийн хувь хэмжээгээр тооцож үзэхэд ахуйн хэрэглээний 1$м^3$ усны үнэ 1939 төгрөг байна

**б/ үйлдвэрлэлд :** Тааш голын сав газарт дээрх хүснэгтэд дурьдсан төлбөрийн хувь хэмжээгээр тооцож үзэхэд технологийн хэрэглээний 1$м^3$ усны үнэ 3,255.0 төгрөг байна.

| Д/д | Ус ашиглах төрөл | 1 $м^3$ усны үнэ/төг | Ашиглах усны хэмжээ | Нийт |
|---|---|---|---|---|
| 1 | Ахуйн хэрэглээнд | 969.5 | 30 $м^3$ | 294,0m3 x 1939.5 = 570,066 төг |
| 2 | Үйлдвэрлэлийн зориулалтаар | 4071.9 | Хэрэглээг тоолуурын заалтаар тооцно. | --*-- |

8. **Төлбөр төлөх хугацаа, данс:** Төслийн талбайд ажил эхэлснээс хойш ажлын 15 хоногийн дотор Төрийн сан ...................... тоот дансанд төвлөрүүлнэ.

9. **Ус ашиглах эрх дуусгавар болоход худгийн барилга байгууламж, тоног төхөөрөмж, бусад эд хөрөнгийг хэрхэх тухай тохиролцоо:**
Ус ашиглах гэрээний хугацаа дуусгавар болоход худагт байгаа насос, ус өргөх хоолойг худагт анх байсан хэвээр үлдээх ба насосыг цахилгаан үүсгүүрт холбоход бүрэн ажиллаж байхаар Ус ашиглуулагчид хүлээлгэн өгнө.

10. **Бусад зүйл:**
    - 10.1.Ус ашиглах явцын зардлыг ус ашиглагч хариуцна.
    - 10.2.Гэрээ байгуулагч талууд Монгол Улсын Усны тухай хуулийн 7.5, 18.1.4, 19.1.2, 19.1.4, 26.1, 30.1, 31.1-дзаасан эрх эдэлж, үүрэг хүлээнэ.
    - 10.3.Гэрээ нь талууд гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарж баталгаажуулсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.
    - 10.4.Талуудын тохиролцсоноор гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж болох ба бичгээр үйлдэнэ.
    - 10.5.Талуудын хооронд үүссэн маргааныг эвийн журмаар шийдвэрлэхийг эрхэмлэх бөгөөд эс зөвшөөрвөл холбогдох шатны шүүхээр шийдвэрлүүлнэ.
    - 10.6.Гэрээний нөхцөлийг биелүүлээгүй, дутуу биелүүлсэн бол буруутай тал холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээнэ.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

УС АШИГЛУУЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:
ГУЧИН УС СУМЫН ЗАСАГ ДАРГА
Х. ЭНХТАЙВАН
..............................

УС АШИГЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:
КАПКОРП МОНГОЛИА ХХК
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
А.ГЭРЭЛТ-ОД
..............................

8. **Төлбөр төлөх хугацаа, данс:** Төслийн талбайд ажил эхэлснээс хойш ажлын 15 хоногийн дотор Төрийн сан ...................... тоот дансанд төвлөрүүлнэ.

9. **Ус ашиглах эрх дуусгавар болоход худгийн барилга байгууламж, тоног төхөөрөмж, бусад эд хөрөнгийг хэрхэх тухай тохиролцоо:**
Ус ашиглах гэрээний хугацаа дуусгавар болоход худагт байгаа насос, ус өргөх хоолойг худагт анх байсан хэвээр үлдээх ба насосыг цахилгаан үүсгүүрт холбоход бүрэн ажиллаж байхаар Ус ашиглуулагчид хүлээлгэн өгнө.

10. **Бусад зүйл:**
10.1. Ус ашиглах явцын зардлыг ус ашиглагч хариуцна.
10.2. Гэрээ байгуулагч талууд Монгол Улсын Усны тухай хуулийн 7.5, 18.1.4, 19.1.2, 19.1.4, 26.1, 30.1, 31.1-дзаасан эрх эдэлж, үүрэг хүлээнэ.
10.3. Гэрээ нь талууд гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарж баталгаажуулсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.
10.4. Талуудын тохиролцсоноор гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж болох ба бичгээр үйлдэнэ.
10.5. Талуудын хооронд үүссэн маргааныг эвийн журмаар шийдвэрлэхийг эрхэмлэх бөгөөд эс зөвшөөрвөл холбогдох шатны шүүхээр шийдвэрлүүлнэ.
10.6. Гэрээний нөхцөлийг биелүүлээгүй, дутуу биелүүлсэн бол буруутай тал холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээнэ.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

| | |
|---|---|
| УС АШИГЛУУЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:<br>ГУЧИН УС СУМЫН ЗАСАГ ДАРГА<br>Х. ЭНХТАЙВАН<br>.............................. | УС АШИГЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:<br>КАПКОРП МОНГОЛИА ХХК<br>ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ<br>А.ГЭРЭЛТ-ОД<br>.............................. |

Хавсралт 9. Гучин-Ус сумын засаг даргын худаг ашиглах зөвшөөрөл

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ГУЧИН-УС СУМЫН ЗАСАГ ДАРГА

4 дүгээр баг, Гучин-Ус сум, Өвөрхангай аймаг, 62185,
Утас (976) 7032 6702, Цахим хаяг: guchin-us@ov.gov.mn,
Цахим хуудас: www: guchin-us.ov.gov.mn

2023.04.18 № 1/64

танай ____________-ны № ______________-т

КАПКОРП МОНГОЛИА ХХК-Д

Тус сумын 3 дугаар багийн Зүүн нүхт гэдэг газар 45⁰10'13.58"N; 101⁰57'38.29"E солбилцол бүхий унд, ахуйн зориулалттай худгийг ашиглахыг зөвшөөрч байна.

Ж.ЭНХТАЙВАН

Хавсралт 10. Худгийн пасспорт


GU-K1

УСНЫ МЭДЭЭЛЛИЙН САН

Байгаль орчны Сайдын
2004 оны 185 тоот
тушаалаар батлав.

ӨРӨМДМӨЛ ХУДГИЙН
ТЕХНИКИЙН ПАСПОРТ

ЭНЭХҮҮ ПАСПОРТЫГ ХУДАГ ЭЗЭМШИГЧ ӨМЧИЛНӨ

Сум, дүүрэг, хороо Өвөрхангай аймаг, Гучин-Ус сум

Эзэмшигч иргэн, байгууллагын нэр "Капкорп Монголиа" ХХК

Өрөмдмөл худгийн нэр ..............................................................

Улсын №

Байршиж буй газрын нэр, хаяг Өвөрхангай аймаг, Гучин-ус сум

Усны ашиглах гэрээний №

Ус ашиглах эрхийн бичгийн нэр №

Худаг гаргасан (аж ахуйн нэгж) "Эрдэнэдрийлинг" ХХК

тамга

ЭРДЭНЭДРИЙЛИНГ ХХК

Захирал ........ Б. Шинэтуяа

2018 он 06 сар 22 өдөр

Баталгаажуулсан:/

Өвөрхангай аймаг (нийслэл)-ийн Байгаль орчны албаны

тамга

Дарга ..............................

2022 он 04 сар 20 өдөр

4

**Худгийн байршлын солбилцол**

Уртраг: 722650.28

Өргөрөг: 5006149.0

Үнэмлэхүй өндөр: 1568 м,

АЙмгийн код Сумын код Худгийн зориулалтын код

| Аймгийн код | Сумын код | Худгийн зориулалтын код |
|---|---|---|
| | | |

Өвөрхангай аймгийн, хотын Гучин-Ус сумын дүүргийн, хорооны, багийн Аргалант Эрдэс гэдэг газарт, Уул уурхай-д зориулан.
(усжуулалт, усан хангамж г.м)

Улаанбаатар аймгийн, (хотын) Эрдэнэдрийлинг компаний Эрдэнэбаатар менежер ахлагчтай анги, бригад Schramm T685 WS маркийн станокоор Шаварт эргүүлэх аргаар уул худгийн цооногийг 2018 он 05 сарын 29-өдрөөс 2018 он 06 сарын 03 өдөр хүртэл өрөмдөж гаргав.

5

Хавсралт 11. Өрөмдлөг, ахуйн хэрэглээнд худгаас авч ашигласан усны бүртгэл

| WATER USAGE LOG FOR VR - 1B TECHNICAL WATER CONSUMPTION | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Date | Day No. | Beginning Balance (m³) | Daily Usage (m³) | Ending Balance (m³) | From Block V (m³) | For Camp Use (m³) | For Mud Tanks and Rig Water | Cement Jobs (m³) | Road Watering (m³) | Comm |
| Prepared and Recorded by Major Drilling . Audited and Verified by Capcorp Senior Drilling Engineer | | | | | | | | | | |
| 5/31/2023 | Wed | | 15 | | | 4 | 11 | | | |
| 6/1/2023 | Thu | | 31 | | | | 31 | | | |
| 6/2/2023 | Fri | | 45 | | | 9 | 36 | | | |
| 6/3/2023 | Sat | | 40 | | | | 40 | | | |
| 6/4/2023 | Sun | | 40 | | | | 40 | | | |
| 6/5/2023 | Mon | | 54 | | | 5 | 49 | | | |
| 6/6/2023 | Tue | | 30 | | | 10 | 20 | | | |
| 6/8/2023 | Thu | | 20 | | | | 20 | | | |
| 6/9/2023 | Fri | | 30 | | | 10 | 20 | | | |
| 6/10/2023 | Sat | | 4 | | | | 4 | | | |
| 6/13/2023 | Thu | | 10 | | | 10 | | | | |
| 6/15/2023 | Thu | | 7 | | | | 7 | | | |
| 6/16/2023 | Fri | | 10 | | | | 10 | | | |
| 6/17/2023 | Sat | | 10 | | | | 10 | | | |
| 6/18/2023 | Sun | | | | | | | | | |
| 6/19/2023 | Mon | | 39.5 | | | 9.5 | 30 | | | |
| 6/20/2023 | Tue | | 30 | | | | 30 | | | |
| 6/21/2023 | Wed | | | | | | | | | |
| 6/22/2023 | Thur | | 40 | | | 10 | 30 | | | |
| 6/23/2023 | Fri | | 34 | | | | 34 | | | |
| 6/24/2023 | Sat | | 27 | | | 10 | 17 | | | |
| 6/25/2023 | Sun | | | | | | | | | |
| 6/26/2023 | Mon | | | | | | | | | |
| 6/27/2023 | TUE | | 44 | | | 10 | 34 | | | |
| 6/28/2023 | WED | | | | | | | | | |
| 6/29/2023 | THU | | 37 | | | 10 | 18 | | 9 | |
| 6/30/2023 | FRI | | 18 | | | | 18 | | | |
| 7/1/2023 | SAT | | 10 | | | 10 | | | | |
| 7/2/2023 | SUN | | 36 | | | | 36 | | | |
| 7/3/2023 | MON | | 46 | | | 10 | 36 | | | |
| 7/4/2023 | TUE | | 18 | | | | 18 | | | |
| 7/5/2023 | WED | | 28 | | | 10 | 18 | | | |
| 7/6/2023 | THU | | | | | | | | | |
| 7/7/2023 | Fri | | 10 | | | 10 | | | | |
| 7/8/2023 | Sat | | | | | | | | | |
| 7/9/2023 | Sun | | 10 | | | 10 | | | | |
| 7/10/2023 | Mon | | | | | | | | | |
| 7/11/2023 | TUE | | 28 | | | 10 | 18 | | | |
| 7/12/2023 | Wed | | 15 | | | | 15 | | | |
| 7/13/2023 | Thu | | | | | | | | | |
| 7/14/2023 | FRI | | 37 | | | 10 | 27 | | | |
| 7/15/2023 | SAT | | 9 | | | | 9 | | | |
| 7/16/2023 | SUN | | 18 | | | | 18 | | | |
| 7/17/2023 | MON | | 28 | | | 10 | 18 | | | |
| 7/18/2023 | TUE | | 28 | | | 10 | 18 | | | |
| | | | | | | | | | | |
| TOTALS | | | 937 | | 0 | 188 | 740 | 0 | 9 | |
| GRAND TOTAL | | 936.5 | | | | | | | | |
| | | | | | | | | | | |
| | | | | | | | | | | |
| | | 181,781.25 | | усны тоолуурын заалт | | | | | | |
| | | 2,408,700.00 | | ажил дуусаж тоолуур салгах үед | 3537 | | | | | |
| | | 2,590,481.25 | | ажил эхлэж тоолуур лацдах үед | 2811 | | | | | |
| | | | | нийт хэрэглэсэн ус тоолуурын заалтаар | 786 | | | | ус ашигласны төлбөрийг тооцвол | |
| | | | | гэрээнд зааснаар ажлын хэрэглээнд | | | | 234 | 285,033.00 | |

Хавсралт 12. Ус ашигласны төлбөрийн баримт

ГОЛОМТ БАНК
*Сайн сайхныг санхүүжүүлнэ*

**Цахим гүйлгээний баримт**

Хүсэлтийн лавлах дугаар: 202459804 | Татсан огноо: 2023-10-10 12:21

| Шилжүүлэгчийн дансны дугаар | Хүлээн авагчийн данс | Гүйлгээний дүн | Гүйлгээний төлөв |
|---|---|---|---|
| **8145100130**<br>MN780015008145100130 | **1165117377** | **2,171,673.00 MNT** | **Амжилттай** |
| Шилжүүлэгчийн нэр<br>**КАПКОРП МОНГОЛИА ХХК** | Хүлээн авагчийн нэр<br>**ТАХ**<br>Хүлээн авагчийн банк | Гүйлгээний утга<br>**2230801204893;51101241315;5077982;51101241315;86102118**<br>Гүйлгээний огноо<br>**2023-08-15** | |

| Гүйлгээг шивсэн хэрэглэгч | Гүйлгээг хянасан хэрэглэгч | Гүйлгээг баталсан хэрэглэгч |
|---|---|---|
| **М. Нямсүрэн** | **Б. ТАМИР** | **ж. Майкл** |

ГОЛОМТ БАНК 01 ХУУЛБАР ҮНЭН

Бүх эрх хуулиар хамгаалагдсан.© Голомтбанк ХХК.

Хавсралт 13. Кемпийн ахуйн хог хаягдлыг зохицуулах гэрээ

БАТЛАВ
БАРУУНБАЯН-УЛААН
СУМЫН ЗАСАГ ДАРГА
Д.БААТАРЧУЛУУН

БАТЛАВ
КАПКОРП МОНГОЛИА ХХК
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
А.ГЭРЭЛТ-ОД

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН БАРУУНБАЯН-УЛААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР, ГАЗРЫН ТОСНЫ ХАЙГУУЛЫН КАПКОРП-ХХК-ТАЙ БАЙГУУЛСАН ХОГ ХАЯГДЛЫГ ЗОХИЦУУЛАХ АЖЛЫН ГЭРЭЭ

**Гэрээний зорилго**

Тус сумын Засаг даргын Тамгын газар, 3 дугаар багийн нутаг дахь "Онги 5" гэрээт талбайд газрын тосны хайгуулын ажил гүйцэтгэх "Капкорп Монголиа" ХХК-ний Хог хаягдлын тухай хуулийн дагуу энгийн хог хаягдлыг цэвэрлэх, ангилан ялгах хадгалах, тээвэрлэх үйл ажиллагааг зохицуулахад оршино.

Нэг талаас Баруунбаян-Улаан сумын 3 дугаар багийг төлөөлж Багийн Засаг дарга ажилтай Г.Пүрэвсүрэн нөгөө талаас "Капкорп Монголиа" ХХК-ийг төлөөлж Байгаль орчны мэргэжилтэн ажилтай Д.Буянзул нар харилцан тохиролцож энэхүү гэрээг байгуулав.

**Гэрээний хугацаа**

2023 оны 05 дугаар сарын 22-ны өдрөөс 2023 оны 07 дугаар сарын 22-ны өдөр хүртэл 60 хоногийн хугацаанд хүчинтэй байна.

Талууд гэрээний хугацааг харилцан тохиролцсоны үндсэн дээр сунгаж болно.

**Сумын удидлага болон багийн удирдлагуудаас хүлээх үүрэг**

1.Тус сумын 3 дугаар багийн нутаг "Ботиулын доод хөл" хэмээх газар байршилтай Газрын тосны хайгуулын "Капкорп Монголиа" ХХК-ний туслан гүйцэтгэгч "Майжер" ХХК-ний хайгуулын өрөмдлөгийн болон суурьшлын бүсэд энгийн хог хаягдлыг хадгалах түр цэг байгуулах ажилд хяналт тавих

2.Тус компаний энгийн хог хаягдлаа цэвэрлэх, ангилан ялгах, хадгалах, тээвэрлэх, сумын төвийн нийтийн хогийн цэгт төвлөрүүлж байгаа эсэхэд хяналт тавих

3. Орон нутгийн чанартай авто зам, гадаргын ус, ой, ургамлын бүрхэвч, суурьшлын бүс болон өрөмдлөгийн талбайд ил задгай хог хаягдал хаяхгүй байхыг анхааруулах байгаль орчныг бохирдлоос хамгаалах

4. Хог хаягдлын талаар иргэдээс ирүүлсэн гомдол мэдээллийг хүлээн авч шийдвэрлэх

5. Аюултай хог хаягдлыг хүлээн авахгүй байх

6. Хайгуулийн ажил дуусахад талбайг хүлээн авах

**Капкорп Монголиа ХХК-ний хүлээх үүрэг**

1.Тус сумын 3 дугаар багийн нутаг "Ботиулын доод хөл" хэмээх газар байрласан Газрын тосны хайгуулын "Капкорп Монголиа" ХХК-ний туслан

гүйцэтгэгч Майжер ХХК-ний хайгуулын өрөмдлөгийн болон суурьшлын бүсэд энгийн хог хаягдлыг хадгалах түр цэг байгуулна.

2.Түр цэг нь хог хаягдал байгаль орчинд салхиар зөөвөрлөгдөж тархахгүй байхаар хийгдсэн байх

3. Түр цэгт хадгалсан хогийг сумын төвийн нийтийн хогийн цэгт 7 хоногт 1 удаа зөөвөрлөж төвлөрүүлнэ.

4. Хог хаягдлыг гаргахдаа ангилан ялгаж уут, саванд хийж битүүмжилсэн байна.

5. Хог хаягдлыг тээвэрлэх ажлыг тус сумын малчид иргэдтэй гэрээ байгуулж гүйцэтгүүлнэ.

6. Орон нутгийн чанартай авто зам, гадаргын ус, ой, ургамлын бүрхэвч, суурьшлын бүс болон өрөмдлөгийн талбайд ил задгай хог хаягдал хаяхгүй байх, орчныг бохирдлоос хамгаалах

7. Хог хаягдлын тухай хуулийн дагуу хог хаягдал гаргасны хураамжийг сумын татварын албанаас тогтоосон тарифын дагуу холбогдох төсвийн дансанд төлж барагдуулна.

8. Жорлон, бохирын цооногийг байгуулахдаа байгаль орчинд ээлтэй жорлонгийн шинэ шийдлийг ашиглах бөгөөд хөрсний бохирдол үүсгээгүй байна.

9. Стандартын хог ангилан ялгах зориулалтын савнуудыг тодорхой газруудад байрлуулах

10. Аюултай хог хаягдал гаргасан тохиолдолд мэргэжлийн байгууллагад хүргүүлж устгуулах

11. Хайгуулийн ажил дуусахад талбайг хүлээлгэн өгөх

**Хариуцлага**

Гэрээ байгуулагч талууд өөрсдийн хариусан үүргийг биелүүлэх бөгөөд хог хаягдлын талаар гарсан гомдол мэдээллийг холбогдох хуулийн дагуу шийдвэрлэнэ.

**Гэрээ хүчин төгөлдөр болох**

Гэрээ байгуулагч талууд гэрээнд гарын үсэг зурснаар гэрээ хүчин төгөлдөр болно

**Гэрээ байгуулсан:**

Баруунбаян-Улаан сумын
3-р багийн Засаг дарга
Г.Пүрэвсүрэн

2023 оны ...... сарын ....ний өдөр

Капкорп Монголиа" ХХК-ний
Байгаль орчны мэргэжилтэн
Д.Буянзул

2023 оны 5... сарын 29 ний өдөр

Хавсралт 14. Ахуйн хог хаягдлын зөөвөрлөсөн бүртгэл

VR-1B Major Drilling

| | Хуванцар / plastic (хэмжээ, quantity) | Цаас/Wood | Шил/Glass | Бусад/ other (хэмжээ, quantity) | Хог хаягдлыг дахин ашиглах цэг, дахин боловсруулах газарт хүлээлгэн өгсөн эсэх/ recycled waste | Дахин ашиглагдахгүй хог хаягдлыг тээвэрлэн хүргэх цэг / waste landfill destination | Хог хаягдлыг ачсан тээврийн хэрэгслийн улсын дугаар / Vehicle plate no | Хог хаягдлыг хүлээн авч тээвэрлэсэн жолоочийн нэр, холбоо барих дугаар / Driver's name and signature | Хог хаягдлыг хүлээлгэн өгсөн хэсгийн ангийн дарга ажилчны нэр / signature of person/ entity who receives handover waste | Хог хаягдлын ачилт хийж тээвэрлүүлсэн фото зургийн баримтжуулалт/ Photographic documentation of waste disposed of |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 June23 | 15KG | 3KG | 1KG | 20KG | 40KG | BBU Soum | 0278 OBO | B. Bat-Erdene | Бат-Эрдэнэ | ATTACHED |
| 8 June23 | 10KG | — | 1KG | 30KG | 25KG | BBU Soum | 0278 OBO | B. Bat-Erdene | Бат-Эрдэнэ | ATTACHED |
| 16 June | 13KG | 3,5KG | — | 25KG | 41.5KG | BBU Soum | 0278 OBO | B. Bat-Erdene | Бат-Эрдэнэ | Attached. |
| 23 June | 23KG | 4KG | 1KG | 20KG | 48KG | BBU Soum | 0278 OBO | B. Bat-Erdene | Бат-Эрдэнэ | attached. |
| — | 10KG | 2KG | — | 15KG | 27KG | BBU Soum | 0278 OBO | B. Bat-Erdene | Бат-Эрдэнэ | attached. |
| 30 June | 5KG | 2KG | — | 25KG | 30KG | BBU Soum | 0278 OBO | B. Bat-Erdene | Бат-Эрдэнэ | ATTACHED |
| 08 July | 10KG. | 2KG | — | 20KG | 25KG. | BBU Soum. | 0278 OBO. | B. Bat-Erdene. | Бат-Эрдэнэ | |
| 17 July | 13KG | 3KG | — | 25KG | 41KG | BBU Soum | 0278 OBO | B. Bat-Erdene | Бат-Эрдэнэ | attached. |
| 22 July | 500кг | — | — | 30кг | — | BBU Soum | 0278 OBO | B. Bat-Erdene | Д. Буянгүүс- Бат-Эрдэнэ | attached |
| 23 July | 250кг | 2кг | — | 200кг | — | BBU Soum | 0278 OBO | B. Bat-Erdene | Бат-Эрдэнэ | attached |

Хавсралт 15. Ахуйн хог хаягдлын төлбөр төлсөн баримт

ГОЛОМТ БАНК
Сайн сайхны санхүүжүүлэгч

**Цахим гүйлгээний баримт**

Хүсэлтийн лавлах дугаар: 189271220

Татсан огноо: 2023-06-06 17:21

| Шилжүүлэгчийн дансны дугаар | Хүлээн авагчийн данс | Гүйлгээний дүн | Гүйлгээний төлөв |
|---|---|---|---|
| **8145100130**<br>IBAN: MN78 0015 0081 4510 0130 | **1165117377**<br>IBAN: MN03 0015 0011 6511 7377 | **885,500.00 MNT** | **Амжилттай** |
| Шилжүүлэгчийн нэр<br>**КАПКОРП МОНГОЛИА ХХК** | Хүлээн авагчийн нэр<br>**ТАХ**<br>Хүлээн авагчийн банк | Гүйлгээний утга<br>**2230600238654;51101241315001;5077982;51101241315001;88786124**<br>Гүйлгээний огноо<br>**2023-06-06** | |

ГОЛОМТ БАНК
01 ХУУЛБАР ҮНЭН

Хавсралт 16. Ахуйн бохир ус нийлүүлэх гэрээ (кемпийн үйлчилгээний гэрээт Геомин ХХК)

БАТЛАВ:
"ОНГИ-УС СУВАГ" ОНӨААТҮГазар
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
Ц.ХОРОЛСҮРЭН

БАТЛАВ:
"ГЕОМИН" ХХК-НИЙ
ЗАХИРАЛ
Г.БАТ-ЭРДЭНЭ

## БОХИР УС НИЙЛҮҮЛЭХ ГЭРЭЭ

2022.05.31

Энэхүү Гэрээг нэг талаас, "ОНГИ-УС СУВАГ" ОНӨААТҮГ, түүнийг төлөөлөн Ерөнхий инженер Б.Даваадавга (цаашид "Хангагч" гэх), нөгөө талаас "ГИОМИН" ХХК-ийг төлөөлөн Менежер Б.Мөнхбат (цаашид "Хэрэглэгч" гэх) нар (хамтад нь "Талууд" гэх) Иргэний хууль, Хот суурины ус хангамж, ариутгах татуургын тухай хууль болон бусад холбогдох хууль, тогтоомж, дүрэм журмын хүрээнд харилцан тохиролцож, хангагч нь унд - ахуйн стандартын шаардлага хангасан хэрэгцээний усаар хангах, хэрэглэгч нь хэрэглэсэн хэрэгцээний усны төлбөрийг гэрээнд заасан хугацаанд төлж барагдуулах үүрэг хүлээж энэхүү гэрээг байгуулав.

### НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Хангагч хэрэглэгчийн хооронд үүссэн харилцааг зохицуулах, гэрээний нөхцөл, тавигдах шаардлага, үйлчилгээний түвшин, бохир усны найрлаг, тоо хэмжээ, төлбөр тооцооны нөхцөл, хангагч хэрэглэгчийн эрх, үүрэг хариуцлагыг өндөржүүлэхэд гэрээний зорилго оршино.

1.2. Талууд Монгол Улсын Иргэний хууль, Хот суурины ус хангамж, ариутгах татуургын тухай хууль, Хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах тухай хууль, ХСУХАТАҮЗЗөвлөлөөс баталсан үнэ тариф зэргийг үндэслэн энэхүү гэрээг байгуулав.

1.3. Хэрэглэгч нь зохих журмын дагуу тогтоосон цэгт бохир усыг батлагдсан хугацаанд нийлүүлэх, төлбөрийн үлдэгдэлгүй байна.

1.4. Энэхүү гэрээгээр хэрэглэгч нь 2023 оны 06 дугээр сарын 02 ний өдрөөс эхлэн 2023 оны 12 дугаар сарын 31-нийг дуустал хүчин төгөлдөр болно.

### ХОЁР. ХАНГАГЧИЙН ЭРХ ҮҮРЭГ

2.1. Монгол Улсын Иргэний хууль, Хот суурины ус хангамж, ариутгах татуургын тухай хууль, Хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах тухай хууль, хангагч хэрэглэгчийн хооронд байгуулсан аж ахуйн гэрээ болон бусад хууль, тогтоомж, дүрэм журамд заасан эрх эдэлж, үүрэг хүлээнэ.

2.2. Хангагч нь хэрэглэгчээс нийлүүлсэн бохир усны төлбөрийг хугацаанд нь бүрэн төлөхийг шаардах эрхтэй.

2.3. Хангагч нь хэрэглэгчийн эзэмшлийн шугамын ашиглалт, тооцооны хэмжүүрийн үнэн зөв эсэхийг шалгах зорилгоор хэрэглэгчийн төлөөллийн хамт барилга байгууламжид нь нэвтрэн орох, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах талаар хугацаатай шаардлага, мэдэгдэл өгөх, акт тавих эрхтэй.

2.4 Хангагч нь цэвэрлэх байгууламж болон шугам сүлжээний төлөвлөгөөт болон урьдчилан сэргийлэх засвар, үйлчилгээ хийх, хэрэглээг хязгаарлах бол хязгаарлалтын талаар хэрэглэгчид урьдчилан мэдэгдэх, шаардлагатай арга хэмжээ авна.

2.5. Хангагч нь хэрэгцээний усны чанар стандарт, түүнээс холбогдон гарсан аливаа асуудалд хариуцлага хүлээхгүй.

2.6 Хангагч нь хэрэглэгчээс гарсан санал хүсэлтийг хүлээн авч шуурхай барагдуулах үүрэгтэй.

2.7 Хангагч үнэ тарифыг өөрчилсөн тухай бүрд хэрэглэгчид энэ тухай албан ёсоор мэдэгдэх үүрэгтэй.

2.8 Хангагч нь өөрийн эзэмшлийн дамжуулах шугам, тоноглолд төлөвлөгөөт таслалт хийх шаардлага гарсан үед 72 цагийн өмнө хэрэглэгчид мэдэгдэх үүрэгтэй.

### Гурав. Хэрэглэгчийн эрх үүрэг

3.1 Монгол Улсын Иргэний хууль, Хот суурины ус хангамж, ариутгах татуургын тухай хууль, Хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах тухай хууль, хангагч хэрэглэгчийн хооронд байгуулсан аж ахуйн гэрээ болон бусад хууль, тогтоомж, дүрэм журамд заасан эрх эдэлж, үүрэг хүлээнэ.

3.2 Хэрэглэгч нь үйлчилгээний болон төлбөрийн талаар санал гомдлоо гаргаж, эрх ашгаа хамгаалуулах эрхтэй.

3.3 Хэрэглэгч нь өөрийн эзэмшлийн шугамд засвар үйлчилгээ хийлгэх шаардлагатай үед хангагчид захиалга өгч засвар үйлчилгээ авах эрхтэй. Засвар үйлчилгээний зардлыг хангагчийн баталсан үнэ тарифын дагуу төлөх үүрэгтэй.

3.4 Хэрэглэгч нь хэмжүүрийн найдвартай ажиллагааг хангах үүднээс суурилуулах, баталгаажуулах, шалгуулах, хэмжүүрийн бүрэн бүтэн байдал, ашиглалт, засвар үйлчилгээг хариуцна.

3.5 Шугамын холболтыг зөвхөн хангагчийн зөвшөөрөл, хяналтын дор гүйцэтгэнэ.

3.6 Хэрэглэгч нь нийлүүлсэн бохир усны төлбөрөө гэрээнд заасан хугацаанд нь төлөх үүрэгтэй.

3.7 Хэрэглэгч нь илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах зорилгоор хангагчаас тавьсан акт, шаардлага, мэдэгдлийн заалтыг хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.8 Хэрэглэгч өөрийн байршил, харилцагч банк, дансны дугаар, хаягийн бүртгэл солигдох, өөрчлөгдөх бүрд хангагчид энэ тухай мэдэгдэх ба гэрээнд шинэчилсэн тодотгол хийлгэх үүрэгтэй.

3.9 Хэрэглэгч нь хангагч байгууллагын шугам сүлжээнд бохир ус нийлүүлэхдээ Хүрээлэн байгаа орчин Усны чанар Ариутгах татуургын сүлжээнд нийлүүлэх хаягдал усны Ерөнхий шаардлага MNS 65 61 : 2015 стандартыг мөрдөж нийлүүлэх.

3.10 Хэрэглэгч нь итгэмжлэгдсэн лабораторид бохир усны шинжилгээг тогтмол хийлгэж хангагч байгууллагад хүргүүлэх.

### Дөрөв. Төлбөр тооцоо

4.1 Хэрэглэгчийн тухайн сард нийлүүлсэн бохир усны хэмжээг авто машины ёмкосны хэмжээгээр тооцно.

4.2 Хэрэглэгч нь тухайн сарын нийлүүлэх бохир усны хэмжээний үнийн дүнтэй тэнцэх урьдчилгаа төлбөрийг хангагчийн дансанд байршуулсны дараа бохир усыг нийлүүлнэ.

4.3 Гэрээт талууд хангагчаас баталсан үнэ тарифыг мөрдөж ажиллана. 1 м³ бохир усыг [redacted] төгрөгөөр байгууллагын 5540020435 тоот дансанд нийлүүлнэ. Үүнд цэвэрлэх байгууламжийн ажиллах хүч, тоног төхөөрөм болон бусад зардал шингэсэн болно.

4.4 Хэрэглэгч нь тухайн сард нийлүүлсэн бохир усны төлбөрийг хангагчийн нэхэмжлэхийг үндэслэн дараа сарын эхний 5 хоногийн дотор бүрэн барагдуулна.

4.5 Хангагч нь энэ гэрээнд заасны дагуу төлбөрөө хугацаанд нь төлөөгүй, гэрээний үүргээ биелүүлээгүй хэрэглэгчид хугацаа хэтэрсэн хоног тутамд төлөгдөөгүй төлбөрийн үнийн дүнгийн 0.5 хувьтай тэнцэх алданги ноогдуулна. Нийт алдангийн хэмжээ нь төлөгдөөгүй төлбөрийн үнийн дүнгийн 50%-иас хэтрэхгүй байна.

4.6 Хангагч нь шаардлагатай гэж үзвэл хэрэглэгчийн сарын дундаж хэрэглээний үнийн дүнтэй тэнцэх мөнгөн барьцааг хангагчийн дансанд байршуулсны дараа бохир усыг хүлээж авах.

Барьцаа мөнгийг усны төлбөрт тооцохгүй, зөвхөн хөренгийн баталгаа болгох ба гэрээ цуцалсны дараа эргүүлж олгоно.

4.7 Тооцооны хэмжих хэрэгсэл болон тооцоо хийдэг ажилтны буруугаас гарсан зөрүүг гэрээт талууд харилцан тохиролцож, дараа сарын тооцоонд тайлбартайгаар тусгаж нөхөн тооцоог хийнэ.

4.8 Төлбөр тооцоотой холбоотой асуудлын талаар хэрэглэгч нь хангагчид 48 цагийн дотор албан ёсоор мэдэгдэнэ. Заасан хугацаанд асуудлаа тавиагүй тохиолдолд хөөн хэлэлцэхгүй. Хангагч нь мэдэгдэл хүлээн авснаас хойш 7 хоногийн дотор асуудлыг шийдвэрлэнэ.

4.9 Хангагчаас хэрэглэгчид үзүүлэх зарим үйлчилгээг батлагдсан тарифын дагуу төлбөртэй гүйцэтгэнэ.

## ТАВ. ГЭНЭТИЙН БОЛОН ДАВАГДАШГҮЙ ХҮЧИН ЗҮЙЛС

5.1 Гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйлсийн улмаас талууд Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх боломжгүй болсон тохиолдолд Гэрээний үйлчлэх хугацааг тухайн нөхцөл байдлыг арилгах хүртэл хойшлуулж болно.

5.2 Гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйлсийн улмаас гэрээний үүргийн хугацаа 30 хоногоос дээш хугацаагаар хойшлогдсон тохиолдолд талууд Гэрээг цуцлах эрхтэй.

## ЗУРГАЙ. БУСАД ЗҮЙЛ

6.1. Энэхүү гэрээ нь талууд гарын үсэг зурсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болох ба талууд гэрээний үүргээ зохих ёсоор гүйцэтгэснээр гэрээний үйлчлэл дуусгавар болно.

6.2. Талууд энэхүү гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж болох ба санаачлагч нь албан ёсоор нөгөө талдаа мэдэгдсэнээс хойш 14 хоногийн дотор харилцан тохиролцож нэмэлт, өөрчлөлтийг оруулна. Талууд гарын үсэг зурж баталгаажуулсан нэмэлт, өөрчлөлт нь энэхүү гэрээний салшгүй хэсэг байна.

6.3. Аль нэг тал гэрээг хугацаанаас нь өмнө цуцлах тохиолдолд энэ тухай нөгөө талдаа 14 хоногийн өмнө бичгээр мэдэгдэнэ.

6.4. Гэрээтэй холбогдож үүссэн маргаантай асуудлыг харилцан зөвшилцөх замаар шийдвэрлэхийг эрмэлзэх бөгөөд зөвшилцөлд эс хүрвэл шүүхээр шийдвэрлүүлнэ.

6.5. Хэрэгцээний усны хангамж, төлбөр тооцоо, хэмжих хэрэгсэл, бусад асуудлаар хэрэглэгчдээс ирүүлсэн санал гомдлыг журмын дагуу шийдвэрлэж хариу мэдэгдэнэ.

6.6. Харилцагч талууд гэрээний үүргээ хангалттай сайн биелүүлсэн компани, хувь хүмүүсийг харилцан шагнаж урамшуулж болно.

6.7. Гэрээний хугацаа дуусгавар болоход талууд гэрээний үүргийн биелэлтийг хамтран дүгнэж акт үйлдэнэ.

6.8. Гэрээг Монгол хэл дээр 2% үйлдэж, талууд тус бүр 1%-ийг авах бөгөөд хувиуд ижил тэгш хүчинтэй байна.

**ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:**

| Захиалагчийг төлөөлж: | Гүйцэтгэгчийг төлөөлж: |
|---|---|
| ОНГИ-УС СУВАГ ОНӨААТҮГ-ын | " ГИОМИН " ХХК-ний |
| .................... | .................... |
| Б.ДАВААДАВГА /ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР/ | Б.МӨНХБАТ / МЕНЕЖЕР / |
| Гар утас: 99291447 | Гар утас: 88620888 |

Хавсралт 18. Велосираптор -1 цооногийн өрөмдлөгийн ажлын үед дагаж мөрдсөн “Нэг замын бодлого”

## ВЕЛОСИРАПТОР-1В (VR-1B) ӨРӨМДЛӨГИЙН ТАЛБАЙ ХҮРЭХ НЭГ ЗАМЫН МАРШРУТЫН ЗААВАРЧИЛГАА

Манай компани өөрийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлийг багастах үүрэг хариуцлагын хүрээнд Өвөрхангай аймгийн Баруунбаян-Улаан сумын нутагт өрөмдлөг хийхээр төлөвлөөд байгаа Велосираптор-1В өрөмдлөгийн талбайд хүрэх замын маршрутыг зурагласан. Энэхүү маршрут нь Арвайхээр хотын төвөөс эхлэх ба нийт замын урт 197,4 км үүнээс 95 км хатуу хучилттай зам (саарал өнгөөр тэмдэглэгдсэн), 102,4 км шороон замаас (улбар шар өнгөөр тэмдэглэгдсэн) бүрдэнэ (Зураг-1-ээс харна уу). Замын саад бартаанууд нь хүнд даацын машин явах замыг хязгаарлах, саатуулах хүчин зүйлс болж болзошгүй тул замын маршрутыг гаргахдаа аливаа саад бартаа болох дов толгод ухаа гүвээ, голын сайр, орон нутгийн суурьшлын бүсээс зайдуу явахаар замыг сонгон гаргасан.




*Зураг 1: Нэг замын маршрутын зураг (зургийн тайлбарыг доор үзүүлэв)*

*VR-1B өрөмдлөгийн талбай*
*Хатуу хучилттай зам*
*Шороон зам*
*Сумын төв*
*VR-1B хүртэлх нэг замын маршрут*
*VR-1B хүртэлх нэг замын маршрутын эргэлтийн цэгийн тэмдэглэгээ*
*Бүтээгдэхүүн Хуваах Гэрээт, Онги-V талбайн хил*
*Аймгийн хил*
*Сумын хил*

*Хүснэгт 1: Нэг замын маршрутын хүрээн дэх шороон замын гол эргэлтийн цэгүүдийн координат*

| Нэр | Өргөрөг | Уртраг |
|---|---|---|
| 95 км-ын тэмдэглэгээ (хатуу хучилттай замаас шороон зам руу орох) | 45°48' 33.960 'N | 101°54' 8.760 E |
| Эргэлтийн цэг 1 | 45°39' 17.280 'N | 101°53' 27' E |
| Эргэлтийн цэг 2 | 45°38' 19.400 'N | 101°52' 21.90'E |
| Эргэлтийн цэг 3 | 45°36' 17.220 'N | 102°0' 38.160'E |
| Эргэлтийн цэг 4 | 45°27' 55.800'N | 101°57'10.92'E |
| Эргэлтийн цэг 5 | 45°19' 13.320'N | 102°1' 7.500"E |
| Эргэлтийн цэг 6 | 45°16' 9.464"N | 102°3' 42.290'E |
| Эргэлтийн цэг 7 | 45° 7' 4.663"N | 101°54' 11.60'E |
| Ирвэс -1 Техникийн худаг | 45° 7.991'N | 101° 55.615'E |
| VR-1B-рүү эргэх эргэлтийн цэг | 45°7'50.539"N | 101°51' 45.15'E |
| Орон нутгийн шороон замаас салж VR-1B өрөмдлөгийн цэг рүү эргэх цэг (өрөмдлөгийн цэгээс 370 м) | 45° 5'53.330"N | 101° 50' 27.08'E |




*Зураг 2: Арвайхээр хотоос 95 км-ын тэмдэглэгээ хүртэлх замын маршрут*




*Зураг 3: 95 км-ын тэмдэглэгээнээс эргэлтийн цэг 3 хүртэлх нэг замын маршрут (Эргэлтийн цэг 1 болон 2-ыг оруулсан)*




*Зураг 4: Эргэлтийн цэг 4-өөс эргэлтийн цэг 6 хүртэлх нэг замын маршрут (Эргэлтийн цэг 5-ыг оруулсан)*




*Зураг 5: Эргэлтийн цэг 6-аас эргэлтийн цэг 7 хүртэлх нэг замын маршрут*




*Зураг 6: Эргэлтийн цэг 7-оос VR-1B рүү эргэх эргэлтийн цэг хүртэлх нэг замын маршрут*



*Зураг 7: Орон нутгийн замаас салж шинэ зам үүсгэх цэгээс VR-1B өрөмдлөгийн цэг хүртэлх нэг замын маршрут*

*(Тайлбар: Улаанаар тэмдэглэгдсэн шинэ зам үүсэх цэг хүртэл одоо байгаа орон нутгийн зам ашиглах ба энэ цэгээс өрмийн талбай хүртэл 370м шинэ зам үүсэхээр байна)*

*Хүснэгт 2: Нэг замын маршрутын хүрээн дэх шороон замын гол эргэлтийн цэгүүдийн хоорондын зай*

| Хаанаас | Хүртэлх | Зай **(Ойролцоогоор)** |
|---|---|---|
| 95 км-ын эргэлтийн цэг | Эргэлтийн цэг 1 | 17.7 км |
| Эргэлтийн цэг 1 | Эргэлтийн цэг 2 | 2.3 км |
| Эргэлтийн цэг 2 | Эргэлтийн цэг 3 | 11 км |
| Эргэлтийн цэг 3 | Эргэлтийн цэг 4 | 17 км |
| Эргэлтийн цэг 4 | Эргэлтийн цэг 5 | 18 км |
| Эргэлтийн цэг 5 | Эргэлтийн цэг 6 | 6.83 км |
| Эргэлтийн цэг 6 | Эргэлтийн цэг 7 | 21 км |
| Эргэлтийн цэг 7 | VR-1B- рүү эргэх эргэлтийн цэг | 3.5 км |
| VR-1B-рүү эргэх эргэлтийн цэгээс | VR-1B өрөмдлөгийн талбайд хүрэх шинээр зам үүсэх цэг хүртэл | 4.7 км |
| Шинээр зам үүсэх цэгээс | VR-1B Өрөмдлөгийн талбай хүртэл | 0.37 км |
| Нийт шороон замын хэмжээ | | 102,4 км |

Хавсралт 19. Галын аюулгүй байдлын дүгнэлт

Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2021 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн А/154 дугаар тушаалын 2 дугаар хавсралт

# ГАЛЫН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ДҮГНЭЛТ

Дугаар 0005771

Аж ахуйн нэгж, байгууллагын нэр: "Конкорп Монголиа" ХХК

Хаяг: Өвөрхангай Баруунбаян-Улаан сум. 5-р баг

Ажлын байрны зориулалт, үйл ажиллагааны чиглэл:

Газрын тосны хайгуулын өрөмдлөг

Барилга байгууламжид гал унтраах тоног төхөөрөмж, /гал унтраах автомат болон дохиоллын систем, утаа зайлуулах систем, усан хангамж/ анхан шатны багаж хэрэгсэл, бодис материал зэргийг байрлуулан ашиглахад энэхүү дүгнэлтийг олгоно. /Галын аюулгүй байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3, 19 дүгээр зүйлийн 19.2/

Олгосон 2023 он 06 сар 22 өдөр

Хүчинтэй хугацаа 2024 он 06 сар 22 өдөр хүртэл

Дүгнэлт олгосон:

Өвөрхангай аймаг, нийслэлийн Онцгой байдлын газар /хэлтсийн/ дарга Зөд хурандаа цолтой Д.Зонбаяр

Дүгнэлт гаргасан:

Өвөрхангай аймаг, нийслэлийн Онцгой байдлын газар /хэлтсийн/ Гал түймрийн улсын хяналтын байцаагч ахмад цолтой Б.Балжинням

/Тэмдэг дарна/

Хавсралт 20. Өрөмдлөгийн гэрээт гүйцэтгэгч Мэжор Дриллинг ХХК-ний ВР-1 цооногийн үед хэрэгжүүлж ажиллах БОМТ



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН БАРУУНБАЯН-УЛААН СУМЫН ӨЛЗИЙТ ХОШУУ БАГИЙН НУТАГТ ОРШИХ “ОНГИ-V” ТАЛБАЙД “ГАЗРЫН ТОСНЫ ХАЙГУУЛЫН ЦООНОГ ӨРӨМДӨХ” ТӨСЛИЙН ТУСЛАН ГҮЙЦЭТГЭГЧ “МЭЙЖОР ДРИЛЛИНГ МОНГОЛ” ХХК-ИЙН 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ДОТООДЫН ТӨЛӨВЛӨГӨӨ**

/Газрын тосны хайгуулын тусгай зөвшөөрлийн дугаар: 736/

/Регистрийн дугаар: 5077982/

/Мэйжор Дриллинг Монгол ХХК-ийн регистрийн дугаар: 2704358/

БОМТ-г боловсруулсан, хамтран хэрэгжүүлэх үүрэг хүлээсэн:

“Мэйжор Дриллинг Монголиа” ХХК-ийн ХАБЭАБО-ны хэлтсийн менежер .............DocuSigned by: Ulzii Chuluun 498343897C1D486.......... /Ч.Өлзийсайхан/

БОМТ-г боловсруулсан, хамтран хэрэгжүүлэх үүрэг хүлээсэн:

“КАПКОРП МОНГОЛИА” ХХК-ИЙН ХАБЭАБО-ны хэлтсийн менежер

.............................................................................DocuSigned by: Gary Neale E3C01859846481........./Гари Нийл /

**2023 он**

Хавсралт 21. Өрөмдлөгийн гэрээт гүйцэтгэгч Мэжор Дриллинг ХХК-ний Химийн бодисын ашиглах тусгай зөвшөөрөл

ХИМИЙН ХОРТ БОЛОН АЮУЛТАЙ БОДИСЫГ ЭКСПОРТЛОХ, ИМПОРТЛОХ, ХИЛ ДАМЖУУЛАН ТЭЭВЭРЛЭХ, ҮЙЛДВЭРЛЭХ, АШИГЛАХ, ХУДАЛДАХ, УСТГАХ АЖ АХУЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУСГАЙ

# ЗӨВШӨӨРӨЛ

Огноо: 2022-04-04 Дугаар: 0002148 Улаанбаатар хот

Аж ахуйн нэгжийн нэр: Мэйжордриллинг монгол ГХО ХХК
Аж ахуйн нэгжийн гэрчилгээний дугаар: 9019012091
Регистрийн дугаар: 2704358
Хаяг: Улаанбаатар, Хан-Уул, 3-р хороо, чингисийн өргөн чөлөө, Бармаш барилга

Утас: 70119952, 70119952

**Дараах химийн хортой, аюултай бодис:** Ашиглах **аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг** 2022.04.01-2025.12.31 **хүртэл хугацаагаар олгов.**

| № | Бодисын нэр | | Томъёо | Олон улсын бүртгэлийн дугаар /CAS/ | Ангилал | Үйлдвэрлэсэн улс | Хэмжээ |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Монгол | Олон улсын | | | | | |
| 1 | Хавсралтад дурдсан 62 нэр төрлийн бодис | | | | | | |
| 2 | | | | | | | |
| 3 | | | | | | | |
| 4 | | | | | | | |
| 5 | | | | | | | |
| 6 | | | | | | | |
| 7 | | | | | | | |
| 8 | | | | | | | |

**Улсын хилээр нэвтрүүлэх боомт:** - - -

**Зөвшөөрөл олгосон:** Байгаль орчин, аялал жуулчлалын яам
Төрийн нарийн бичгийн дарга / Э. БАТТУЛГА /

Химийн хорт болон аюултай бодисын бодлого зохицуулалт хариуцсан мэргэжилтэн / Ц.БАТЖАРГАЛ /

**Химийн хорт болон аюултай бодисыг
Ашиглах 0002148 дугаартай
тусгай зөвшөөрлийн хавсралт**

| № | Монгол нэр | Олон улсын нэршил | Томъёо | CAS дугаар | Зөвшөөрсөн хэмжээ, тн |
|---|---|---|---|---|---|
| 1 | Өрмийн алхны тос | Hammer oil 150 | Highly refined parafinnic oil>60% | 5500-88 | 3 |
| 2 | Өрмийн алхны тос | Hammer oil 320 | Highly refined parafinnic oil>60% | 5500-88 | 3 |
| 3 | Өрмийн штангийн тос | Amc liquid rod grease | $CH_2$-O-C(O)-R1<br>CH-O-C(O)-R2<br>$CH_2$-O-C(O)-R3 | 7641-44 | 6 |
| 4 | Өрмийн штангийн тос /өндөр идэвхт/ | Amc rod grease xtra tacky | Barium, acetate tallow fatty acid complex hydrocarbon mineral oil (70-80%) | 64742-52-5 | 12 |
| 5 | Өрмийн хошууны тос | Ep bit lube | Refined Vegetable oil<br>$CH_2$-O-C(O)-R1<br>CH-O-C(O)-$R_2$<br>$CH_2$-O-C(O)-$R_3$ | 6921-10-3 | 12 |
| 6 | Ургамлын гаралтай тастагчийн тос | Amc universal | | 7639-46 | 15 |
| 7 | Ургамлын гаралтай өрөмдлөгийн тос | Penetrol xtra | | 7639-46 | 2.4 |
| 8 | Ургамлын гаралтай өрөмдлөгийн тос | Torque-free xtra | | 7177-11 | 2.4 |
| 9 | Органик полимер | Austrol | $[C_6H_7O_2(OH)_3$-$X(OC_2H_5)X]n$100% ethylcellulose | 9004-57-3 | 15 |
| 10 | Шингэн полимер | Amc-liquid pol | Drilling fluid additive | 60815 | 15 |
| 11 | Сэргээх полимер | Amc-cr-650 | Drilling fluid additive, 100% | 4902-92 | 15 |
| 12 | Полимер, өсдөг | Amc-aus plug | Cross-linked polyacrylamide, 100% | 9003-05-8 | 6 |
| 13 | Нийлэг ко-полимер | Aus-floc | Co-Polymer | 4902-93 | 2.4 |
| 14 | Нийлэг ко-полимер | Aus-floc blocks | | 6089-06 | 2.3 |
| 15 | Цэвэрлэгч полимер | Well clean | Sodium carboxymethyl cellulose, 100% | 7758-16-9 | 1.44 |
| 16 | Полимер, цавуулаг | Amc pac-l | Sodium carboxymethyl cellulose, 100% | 9004-32-4 | 2.3 |
| 17 | Полимер, цавуулаг | Amc pac-r | | | 9 |
| 18 | Полимер, цавуулаг | Ezee pac-r | | | 9 |
| 19 | Өрөмдлөгийн цемент | Gyp-set 15 | Calcium sulfate hemihydrate | 10034-76-1 | 8 |
| 20 | Өрөмдлөгийн цемент | Gyp-set 30 | | 10034-76-1 | 6 |
| 21 | Шингэн цемент | Fr-100l | Naphthalenesulfonic acids | 68153-01-5 | 2.4 |
| 22 | Цементийн нэмэлт | Amc xxx 10 | Calcium chloride 80%<br>fly ash-low quartz 20% | 10043-52-4<br>68131-74-8 | 1 |
| 23 | Цементийн нэмэлт | Amc xxx 15 | | | 1.4 |
| 24 | Өрөмдлөгийн хөөс | Super foam | Anionic surfactants, 60% | 7177-08 | 2.4 |
| 25 | Өрөмдлөгийн нийлэг хөөс | Aus grip a eco | Polyethylene polypropylene glycol glyceryl ether | 9082-00-2 | 1.6 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | determined not to be hazardous >60 | | |
| 50 | Усан суурьтай өрөмдлөгийн шингэнд хэрэглэх зориулалттай силикон суурьтай бүх төрлийн хөөс арилгагч | AUS Defoamer S | - | 26-5533 | 3 |
| 51 | Цардуул | AMC Aus Dex | Холимор >60 | 9005-25-8 | 3 |
| 52 | Органик полимер | AMC Ezee trol | Sodium carboxymethyl cellulose (>60%); sodium carbonate (<5%) | - | 3 |
| 53 | Нимбэгийн хүчил | Citric Acid | Citric acid > -96 | 77-92-9 | 3 |
| 54 | Өндөр чанарын занарын урвал саармагжуулах | Sinomud Kla- stab | Полиамин | 9046-10-0 | 3 |
| 55 | Өрөмдлөгийн шингэний нэгдэл. | AMC Ben Viscosifier. | Bentonite, >94 % | 1302-78-9 | 3 |
| 56 | Өрөмдлөгийн шингэн нэмэлт | AMC Glute 9<br>AMC Glute 50 | Глутаральдегид 50%, ус 50% | 111-30-8<br>7732-18-5 | 3 |
| 57 | Натрийн сульфит | Sodium Sulphite<br>Sodium Sulfate Anhydrous | Sodium Sulphite >95 | 7757-83-7 | 3 |
| 58 | Өрөмдлөгийн нэмэлт шингэн | AMC Quick Seal | Найрлагыг аюулгүй гэж тодорхойлсон, 100 % | 62-2620 | 3 |
| 59 | Сийл лац | Sinomud Seal | Шаараң ноосон эслэг 60-100 % | 65996-69-2 | 3 |
| 60 | Натрийн бикарбонат | AMC Sodium bicarbonate | Sodium bicarbonate >99 | 144-55-5 | 3 |
| 61 | Цемент түргэн хатаагч, усгүйжүүлэгч нэмэлт | BASF MasterRheobuild 1000NT | Calcium naphthalene sulphonate - formaldehyde condensate (25 - 50%) | 37293-74-6 | 3 |
| 62 | Магнийн оксид | Mangnesium Oxide | Магнийн оксид >65 %, кальцийн оксид 1-3 %, үлдсэн аюулгүй найрлага | - | 3 |

Хавсралт 22. Өрөмдлөгийн гэрээт гүйцэтгэгч Мэжор Дриллинг ХХК-ний Аюултай хог хаягдал шилжүүлэх гэрээ

TSETSUUH

SINCE 1996

**"ЦЭЦҮҮХ ТРЕЙД" ХХК**

# АЮУЛТАЙ ХОГ ХАЯГДАЛ ШИЛЖҮҮЛЭХ ГЭРЭЭ

**Огноо:** 2023 оны 06 сарын 05

**Гэрээний дугаар:** **Ш-23/**079

**Хүлээн авагч:**
**"Цэцүүх Трейд" ХХК**

**Хаяг**: Монгол улс, Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 5-р хороо /16010/, Энхтайваны өргөн чөлөө 64/2 тоот "Цэцүүх" оффис, үйлчилгээний төв
**Утас**: +976 70179777, +976 70180632
**Цахим хаяг:** www.tsetsuuh.mn
**Регистрийн дугаар**: 2066521
**Цахим шуудан**: info@tsetsuuh.mn

**Үүсгэгч:**
**"Мэйжор Дриллинг Монгол" ХХК**
**Хаяг:** : Мэйжордриллинг Монгол ХХК, Улаанбаатар Хан-Уул, 3-р хороо, ажилчны гудамж, Шинэст JS Барилга
**Утас:** 77119950
**Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар:** 00017603
**Регистрийн дугаар:** 2704358
**Цахим шуудан** solongobayar.samdantsoodol@majordrilling.com

БАТЛАВ.
"ЦЭЦҮҮХ ТРЕЙД" ХХК
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
................... / Н.БИЛГҮҮН/

БАТЛАВ.
"МЭЙЖОР ДРИЛЛИНГ МОНГОЛ" ХХК
ЗАХИРАЛ
.............../ СЭМЮЭЛ ВИЛЛИАМС

**АЮУЛТАЙ ХОГ ХАЯГДАЛ ШИЛЖҮҮЛЭХ ГЭРЭЭ**

2023 оны 06 сарын 05 өдөр № Ш-23/079 Улаанбаатар хот
Ү-

Нэг талаас **Цэцүүх трейд ХХК** /цаашид "Хүлээн авагч" гэх/ төлөөлж Үйлдвэрийн дарга албан тушаалтай Б.Дарамбазар, Нөгөө талаас .. нөгөө талаас ""Мэйжор Дриллинг Монгол" ХХК-г /тээвэрлүүлэгч гэх/ төлөөлж Хүний нөөцийн ажилтан албан албан тушаалтай Самданцоодол овогтой Солонгобаяр бид харилцан тохиролцож Монгол улсын Иргэний хууль, Хог хаягдлын тухай хууль Засгийн газрын ***2018 оны 116-р тогтоолын 1, 2-р хавсралт болох "Аюултай хог хаягдлыг түр хадгалах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, устгах болон бүртгэх тайлагнах журам", Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2018 оны 02-р сарын 02-ны өдрийн А/21 тоот тушаал*** болон Байгаль орчны аюулгүй байдалтай холбогдох хууль, журмыг үндэслэн энэхүү гэрээг байгуулав.

**Нэг. Гэрээний агуулга**

1.1. Энэхүү гэрээгээр Аюултай хог хаягдал үүсгэгчээс аюултай хог хаягдлын дагалдах бичгийн дагуу түүнээс гарч байгаа аюултай хог хаягдлыг хүлээн авагч нь хүлээн авч хадгалах, дахин боловсруулах, устгалд оруулах, үүсгэгч нь хүлээн авагчид тохиролцсон үнийг төлөх болон талуудын эдлэх эрх, үүрэг хариуцлагын талаар зохицуулна.
1.2. Эл гэрээгээр шууд зохицуулагдаагүй бусад харилцааг Монгол улсын Хог хаягдлын тухай хууль, Иргэний хууль болон бусад хууль тогтоомжоор зохицуулна.
1.3. Аюултай хог хаягдлын тоо хэмжээ, төрөл болон үнийн талаар гэрээний Хавсралт 1-т тусгах ба талууд гэрээний хугацаанд аюултай хог хаягдлыг шилжүүлэх бүртээ дагалдах бичгийг гэрээнд хавсаргах ба энэ нь гэрээний салшгүй хэсэг байна.

**Хоёр. Аюултай хог хаягдалд тавигдах шаардлага**

2.1. Аюултай хог хаягдлыг ангилан ялгаж "Аюултай хог хаягдал" гэсэн тэмдэглэгээтэй байна.
2.2. Аюултай хог хаягдал савласан сав бүр нь ямар химийн бодис хадгалж байсан тухай нэр шошготой байна.
2.3. Үүсгэгч нь аюултай хог хаягдлыг шилжүүлэх бүртээ үүссэн болон хуримтлагдсан хог хаягдлын хэмжээний талаарх бүртгэлийг хүлээн авагчид шилжүүлнэ.
2.4. Аюултай хог хаягдлыг шилжүүлэхдээ ***БОАЖЯСайдын 2018 оны 02-р сарын 02-ны өдрийн А/21 тоот тушаалын 1-р хавсралтад заасан маягтын дагуу дагалдах бичгийг*** бүрдүүлж өгнө.
2.5. Аюултай хог хаягдлын *савыг суллаж онц хортой, тэсрэмтгий, шатамхай бодис /тухайлбал цианид натри гэх мэт/ -г тухайн бодисын шинж чанарт тохирсон уусмалаар цэвэрлэсэн байна.* Хоосон сав нь ЗГ-н 2018 оны 116-р тогтоолын 1-р хавсралтын 5.7-5.9-д заасан шаардлагыг хангасан байвал зохино.
2.6. Үүсгэгч Аюултай хог хаягдлыг "Аюултай хог хаягдал" тээвэрлэх тусгай зөвшөөрөл бүхий Аж ахуй нэгжийн тээврийн хэрэгслээр ачиж, тээвэрлүүлж хүлээн авагчид шилжүүлнэ.

_______________ Хуудсыг баталгаажуулсан: _______________

Хуудас **2/10**

8.3. Гэнэтийн болон давагдашгүй хүчний шинжтэй нөхцөл байдлын улмаас бараа материал устсан, дутсан тохиолдолд шилжүүлэн хүлээлгэн өгөх хүртэлх эрсдэлийг үүсгэгч, шилжүүлэн хүлээн авснаас хойших эрсдэлийг хүлээн авагч хариуцна.

8.4. Гэнэтийн болон давагдашгүй хүчний шинжтэй нөхцөл байдлыг зохиомлоор буюу болгоомжгүйгээр бий болгосноос бусад тохиолдолд форс мажорын нөхцлөөс шалтгаалан учирсан хохирлыг хариуцах үүргээс талууд чөлөөлөгдөнө.

**Ес. Бусад зүйл**

9.1. Энэхүү гэрээний хэрэгжилтийн явцад гэрээнд аливаа нэмэлт, өөрчлөлт оруулах тохиолдолд бичгээр үйлдэж эрх бүхий албан тушаалтан гарын үсэг зурж, тамга дарж баталгаажуулснаар хүчин төгөлдөр болно.

9.2. Гэрээнд оруулах нэмэлт, өөрчлөлтийг зөвхөн бичгээр оруулах ба талуудын эрх бүхий албан тушаалтнууд гарын үсэг зурж, тамга дарж баталгаажуулснаар хүчин төгөлдөр болно.

9.3. Энэхүү гэрээг Монгол хэл дээр хоёр хувь үйлдэж, Үүсгэгч тал 1 хувь, Хүлээн авагч тал 1 хувийг тус тус хадгалсан нь хуулийн ижил хүчинтэй.

**ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:**

**Үүсгэгч талыг төлөөлж:**
. "Мэйжор Дриллинг Монгол" ХХК-ийн
Хүний нөөцийн
ажилтан........................... / Солонгобаяр
..................... /

Суурин утас: (976) 77119950
Гар утас:94212040
Регистер:2704358
УБ гэрчилгээний дугаар: 000176030
Химийн бодис ашиглах, импортлох тусгай зөвшөөрлийн дугаар: 00025148
Хаяг: Мэйжордриллинг Монгол ХХК, Улаанбаатар, Хан-Уул, 3-р хороо, ажилчны гудамж, Шинэст JSC Барилга

Хог хаягдал үүсэх хаяг: Өвөрхангай аймаг, Баруун Баян-Улаан сум болон Өмнөговь аймаг, Номгон сум
Email хаяг:
solongobayar.samdantsoodol@majordrilling.com

Хүлээн авагч талыг төлөөлж:
Цэцүүх Трейд ХХК-ийн
Үйлдвэрийн дарга
_______________ / Б.Дарамбазар /

Нягтлан:
_______________ / Т. Буяндэлгэр /

Суурин утас: 70189778
Гар утас: 99057786
Регистер: 2066521
УБ гэрчилгээний дугаар: 9011026056
Тусгай зөвшөөрлийн дугаар: Б-000001
Хаяг: Баянгол дүүрэг, 5-р хороо, Энхтайвны өргөн чөлөө – 64/2, Цэцүүх Трейд ХХК-ийн оффис, үйлчилгээний байр
Email хаяг: Darambazar@tsetsuuh.mn
Шуудангийн хаяг: ШХ-1138

_______________ Хуудсыг баталгаажуулсан: _______________

Хуудас **6/10**

Хавсралт 23. Өрөмдлөгийн гэрээт гүйцэтгэгч Мэжор Дриллинг ХХК-ний Аюултай хог хаягдлыг шилжүүлсэн дагалдах бичиг

*Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2018 оны 02 сарын 02-ны өдрийн А/21 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт*

**АЮУЛТАЙ ХОГ ХАЯГДАЛ ХАЯГДЛЫН ДАГАЛДАХ БИЧИГ**

№0000589

**Дагалдах бичгийн дугаар:**
*/шаардлагатай тохиолдолд нэмэлт хуудас хэрэглэнэ./*

**1.Үүсгэгчийн талаарх мэдээлэл:**

Аюултай хог хаягдал үүсгэгчийн бүртгэлийн дугаар:

Аюултай хог хаягдал үүсгэгч байгууллагын нэр: Мейжор дриллинг монгол ХХК

**2. Аюултай хог хаягдлыг хүлээлгэн өгсөн:**

Овог нэр: С. Солонгобаяр Албан тушаалтан: хүний нөөц ажилтан Гарын үсэг: Огноо: 2023 он 08 сар 03 өдөр

**3. Тээвэрлэгчийн талаарх мэдээлэл:**

1/ Тээврийн хэрэгслийн улсын дугаар: 85-17 УНО Тээвэрлэгчийн бүртгэлийн дугаар: ..................

**4. Аюултай хог хаягдлын талаарх мэдээлэл:**

| | Аюултай хог хаягдлын нэр | Аюулын ангилалын зэрэглэл | Савлагааны бүлэг | Савны дугаар | Савны Төрөл | Хэмжээ | Нэгж /кг Эсвэл/ш | Аюултай хог хаягдлын код |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Канистр (20л) | × | битүү | | HDPE | 15 | ш | 150109 |
| 2 | шүүдэр | × | битүү | | | 1'100 | кг | 150109 |
| 3 | | | | | | | | |
| 4 | | | | | | | | |

**3. Тээвэрлэх үед анхаарах нэмэлт зааварчилгаа, мэдээлэл:**

**5. Аюултай хог хаягдлыг хүлээн авсан тээвэрлэгч:**

1. Овог нэр: С. Солонгобаяр Гарын үсэг: .......................... 2023 он 08 сар 03 өдөр

**6. Үл зохицол:**

7. Аюултай хог хаягдлыг хүлээн авагчийн талаарх мэдээлэл:

Аж ахуйн нэгжийн нэр: **ЦЭЦҮҮХ ТРЕЙД ХХК**
Цэцүүх трейд ХХК бүртгэлийн дугаар: **Y-001123**

**Аюултай хог хаягдлыг хүлээн авсан.**

Овог нэр: Цэцүүх трейд ХХК Д. Дагорбаа Албан тушаал: нярав Гарын үсэг /тамга/ Огноо: 2023 он 08 сар 03 өдөр

Хавсралт 24. Өрөмдлөгийн гэрээт компаний ажилчдын химийн бодистой харьцаж ажиллах үеийн аюулгүй ажиллагааны сургалтын сертификат

MKL

/Тусгай зөвшөөрөл: 17100326/

# ГЭРЧИЛГЭЭ

Дугаар № 23/С-502

Хүндэт Б.Цогбаяр танд

“Химийн хорт бодистой харьцаж ажиллах үеийн аюулгүй ажиллагаа” нь сэдэвт ХАБЭА-н сургалтанд хамрагдсан тул ГЭРЧИЛГЭЭ олгов.

“МКЛ” ХХК-ийн дэргэдэх сургалтын төвийн захирал

Д.ХОРОЛСҮРЭН

Олгосон: 2023.06.09

MKL

/Тусгай зөвшөөрөл: 17100326/

# ГЭРЧИЛГЭЭ

Дугаар № 23/С-506

Хүндэт Ж.Жанарбаатар танд

"Химийн хорт бодистой харьцаж ажиллах үеийн аюулгүй ажиллагаа" нь сэдэвт ХАБЭА-н сургалтанд хамрагдсан тул ГЭРЧИЛГЭЭ олгов.

"МКЛ" ХХК-ийн дэргэдэх сургалтын төвийн захирал

Д.ХОРОЛСҮРЭН

Олгосон: 2023.06.09

Хавсралт 25. Агаарын түр зурвас тогтоосон акт

## ХЭЭРИЙН ТҮР ЗУРВАС СОНГОСОН АКТ

" Геосон " ХХК-ны 2023.03.31 өдрийн Иргэний нисэхийн үндэсний төвд ирүүлсэн хүсэлтийн дагуу:

Өвөрхангай нисэх буудлын аэродромын техникч Ч.Баттулга , " Геосан " ХХК-ны Агаарын хөлгийн 2-р нисгэгч Э.Амгаланбаатар нар Өвөрхангай аймгийн Гучин-Ус сумын нутагт орших " Үзүүрийн хөндий " гэх газарт түр зурвас сонгож тогтоосон нь.

**Нэг. Түр зурвас, талбайн байрлал**

Өвөрхангай аймгийн Гучин-Ус сумын төвөөс баруун урд зүгт 52 км зайд байрлана.

**Хоёр. Түр зурвас, талбайн техникийн тодорхойлолтууд**

1. Хөөрч буух зурвасны урт — 1000 метр
   Өргөн — 50 метр
2. Нислэгийн зурвасын хэмжээ — 1100x100 метр
3. Төгсгөлийн аюулгүйн зурвас урт — 50x200 метр
4. Хөөрөлт буултын чиглэл — 90/270 градиус
5. Өндөр — 27 талдаа 1324 метр; 09 талдаа 1329 метр
6. Газар зүйн байрлал — N450842.8 E1015603.7; N450842.2 E1015512.5
7. Хөрсний төрөл — Элсэрхэг бор шороон хөрстэй
8. Хучилт хөрсний даац / хуурай нөхцөлд/ — Дунд
9. Ойртолт, оролт, гаралтын нөхцөл — Чөлөөтэй

**Гурав.Түр зурвас, талбайн тоноглол**

1. Салхи заагчийг байрлуулна.
2. Байнгын болон түр тэмдэг дохио тэмдэгт байрлуулна.
3. Агаарын хөлгийн бэхэлгээг байрлуулна.
4. Холбоо нагивацийн тоноглол: Онгоцны КВ холбоо, Иридиум сансарын утас, гар утас / Мобисом, Жи-Мобайл, Юнител, Скайтел/
5. Хөөрч буух зурвасын ил харааны тэмдэгтүүдийг 100 метр тутамд тэгш хэмжээтэйгээр байрлуулна.

**Дөрөв. Орчмын саадууд**

| № | Саадын төрөл | Өндөр / м/ | Зай /км/ | Чиглэл |
|---|---|---|---|---|
| 1 | Бага богд уул | 3590 | 39 | 220 |
| 2 | Хар шил | 1850 | 25 | 48 |
| | | | | |
| | | | | |

**Тав. Орчны тухайн үеийн цаг агаарын онцлог**

Баруун, баруун хойноос зонхилох салхитай.

**Зургаа. Нислэгийн хангалт**

1. Нислэгийн удирдлага: Нислэгийг онгоцны даргын шийдвэрийн дагуу зөвхөн ил хараагаар өдрийн гэрэлтэй цагт нислэг үйлдэж Улаанбаатар хотоос КВ станц, Иридум утас болон гар утсаар холбоо барина.
2. Цаг агаарын хангалт: Тус бүс нутгийн цаг агаарын мэдээг Өвөрхангай аймгийн Гучин-ус сумын ус цаг уур орчны төвөөс КВ станц, сансрын утас болон гар утсаар авна.
3. Хамгаалалт: Захиалагч байгууллага хариуцна. Гадны хүн, мал амьтан, машин механизм нэвтрэхээс урьдчилан сэргийлэх.
4. Нислэгийн хязгаарлалт: Хөндлөнгийн болон арын салхи зөвшөөрөгдсөн хэмжээнээс хэтэрсэн, цас орсон болон гадаргууд эвдрэл үүссэн мөн харагдах орчин хязгаарлагдмал үед нислэг үйлдэхийг хориглоно. Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын 2020 оны 04 сарын 30 өдөр баталсан А/270 тушаалын нэгдүгээр хавсралт дахь Түр зурвас, талбай сонгох, бүртгэх журмын 2.1-д заасны дагуу нислэг үйлдэнэ.
5. Хийгдэх ажлууд: Хөөрч буух зурвас дээрх гадны биет, жижиг хог хаягдлыг түүж цэвэрлэх. Мөн нислэг үйлдэх үед хамгаалалт гаргаж хүн болон мал, амьтны аюулаас сэргийлэх. Хөөрч буух зурвасын зүүн талд бүдгэрсэн авто замын ховилыг шороогоор дүүргэж нягтруулах, хөрч буух зурвасны суларсан гадаргуур талбайг индүүдэж нягтруулах. Нислэгийн аюулгүй байдлыг хангах.
6. Түр зурвас талбайг хариуцах ажилтан:
   Нэр: Капкорп Монголиа компани Байгаль орчны мэргэжилтэн
   Д.Буянзул Утас:99700075

Өвөрхангай аймгийн Гучин-ус сумаас 52 км зайд орших "Үзүүрийн хөндий" гэдэг газарт түр зурвас, талбайг "Cessna-208B" төрлийн агаарын хөлгийг нислэгт 2023 оны ... сарын ....-ны өдрөөс 2023 оны ... сарын ...-ны өдөр хүртэл .... хоног /өдрийн цагаар/ ашиглаж болно.

Өвөрхангай нисэх буудлын аэродромын техникч: Ч.Баттулга ________ Ч.Баттулга
"Геосан" ХХК-ийн Агаарын хөлгийн 2-р нисгэгч: Э.Амгаланбаатар ........ Э.Амгаланбаатар

Долоо. Агаарын тээвэрлэгч байгууллагын гүйцэтгэх захирлын мэдэгдэл

Лхамсүрэн ________ овогтой Мөнхжаргал ________ миний бие энэхүү сонгосон түр зурвас, талбайг Иргэний нисэхийн тухай Монгол улсын хууль, иргэний нисэхийн багц дүрэм, Аэродром төлөвлөлт ба ашиглалтын техникийн баримт бичгийн холбогдох журамд нийцүүлэн ашиглаж, нислэгийн аюулгүй байдал, аюулгүй ажиллагаар бүрэн хариуцаж ажиллахаа батлаж байна. Мөн Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын 2020 оны 04 сарын 30 өдөр баталсан А/270 тушаалын нэгдүгээр хавсралт дахь Түр зурвас, талбай сонгох, бүртгэх журмын 4.1.2-д заасны дагуу "Бизнес захиалгат" нислэг үйлдэнэ.

Баталгаа гаргасан: Геосан ХХК үйл ажиллагаа хариуцсан захирал Н.Мөнхжаргал

Гарын үсэг: ________________________ тамга

Огноо: 2023 оны 04 сарын 17 өдөр

Хавсралт 26. Баруунбаян-Улаан сумын засаг даргын тодорхойлолт

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
БАРУУНБАЯН-УЛААН СУМЫН
ЗАСАГ ДАРГА

2023.09.22 № 1/146

танай ___________-ны №___________-т

АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ ГАЗАРТ

Тодорхойлолт

Засгийн газрын бүтээгдэхүүн хуваах гэрээт /БХГ/ "Онги-V" талбайд Петро Матад группийн охин компани болох "Капкорп Монголиа" ХХК нь АМГТГ-аас баталсан 2023 оны хайгуулын ажлын төлөвлөгөөний дагуу Өвөрхангай аймгийн Баруунбаян-Улаан сумын нутагт "Велосираптор-1" хайгуулын цооногийн өрөмдлөгийн ажлыг 2023 оны 5 дугаар сарын 23-ны өдрөөс 2023 оны 7 дугаар сарын 25-ны хооронд амжилттай хийж гүйцэтгэлээ.

"Капкорп Монголиа" ХХК нь хайгуулын ажлын гүйцэтгэхдээ Монгол улсад мөрдөгдөж байгаа холбогдох хууль тогтоомжууд, ISO 14001 байгаль орчны менежментийн системийн стандарт, ХАБЭА-н менежментийн тогтоолцооны MNS ISO 45001:2018 стандарт, IOGP олон улсын газрын тос, байгалийн хий олборлогчдийн холбооны зөвлөмж, IDAC олон улсын өрөмдлөгийн компаниудийн холбооноос гаргасан зөвлөмжүүдийг дагаж мөрдөн, БХГ-ний дагуу орон нутгийн хөгжлийг дэмжих төсөл хөтөлбөрүүдийг Баруунбаян-Улаан суманд хэрэгжүүлж ажилласныг тодорхойлж байна.

Хайгуулын цооногийн өрөмдлөгийн төслийн хугацаанд тус компани "Нэг замын бодлого" баримтлах, байгаль орчноо хамгаалах, сум орон нутаг, малчин ард иргэдтэй харилцах, улмаар тэдний бүхий л талаар дэмжих ажлыг маш сайн зохион байгуулж хариуцлагатай уул уурхайн компани гэдгээ батлан харуулсан гэдгийг онцгойлон дурьдаж байна.

ДАРГА Д.БААТАРЧУЛУУН

D/My doc alban bichig ZD A4.doc

Хавсралт 27. Гучин-Ус сумын засаг даргын тодорхойлолт

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ГУЧИН-УС СУМЫН ЗАСАГ ДАРГА

2023.09.21 № 1/115

танай ____________-ны №____________-т

ТОДОРХОЙЛОЛТ

Петро Матад группийн охин компани болох "Капкорп Монголиа" ХХК нь АМГТГ-аас баталсан 2023 оны хайгуулын ажлын төлөвлөгөөний дагуу Засгийн газрын бүтээгдэхүүн хуваах гэрээт /БХГ/ "Онги-V" талбайд "Велосираптор-1" хайгуулын цооногийн өрөмдлөгийн ажлыг 2023 оны 5 дугаар сарын 23-ны өдрөөс 2023 оны 7 дугаар сарын 25-ны хооронд амжилттай хийж гүйцэтгэсэн билээ.

"Капкорп Монголиа" ХХК нь хайгуулын ажлын гүйцэтгэхдээ Монгол улсад мөрдөгдөж байгаа холбогдох хууль тогтоомжуудийн бүрэн хэрэгжүүлж, байгаль орчныг хамгаалах, орон нутгийн хөгжлийг дэмжих төсөл хөтөлбөрүүдийг БХГ-ний дагуу жил бүр хэрэгжүүлэн ажилласан.

Тус компани хайгуулын цооногийн өрөмдлөгийн төслийн хугацаанд "Нэг замын бодлого" баримтлах, байгаль орчноо хамгаалах, сум орон нутаг, малчин ард иргэдтэй харилцах, улмаар тэднийг бүхий л талаар дэмжих ажлыг маш сайн зохион байгуулж хариуцлагатай уул уурхайн компани гэдгээ батлан харуулсан гэдгийг онцгойлон дурьдаж байна.

Х.ЭНХТАЙВАН

My.Doc.D.Alban bichig

Хавсралт 28. Яаралтай үед авах хариу арга хэмжээний төлөвлөгөө

Хавсралт 29. Эрүүл мэндийн яаралтай нүүлгэн шилжүүлэлтийн төлөвлөгөө

Хавсралт 30. Үйл ажиллагааны өмнөх орчны хяналт шинжилгээний ажлын тайлан

Хавсралт 31. Үйл ажиллагааны үеийн орчны хяналт шинжилгээний ажлын тайлан

Хавсралт 32. Үйл ажиллагааны дараах үеийн орчны хяналт шинжилгээний ажлын тайлан

Хавсралт 33. Техникийн болон биологийн нөхөн сэргээлтийн ажлын тайлан

Хавсралт 34. Цацраг үүсгүүр ашиглалтын талаарх тайлан